**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**
**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар**

**2024 оны эхний хагас жил**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай 2003-05-30 Дугаар 2003_01 | 15.2.3. Бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах; | УТХО-аар эрх шилжин хэрэгжиж буй 14 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулахаас одоогийн байдлаар 10 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулаад байна. | 100 | | |
| | 2 | | 15.2.4. Бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах; | Ажлын үр дүнгийн талаар тайлагнах хугацаа болоогүй. | ХБ | | |
| 2 | 3 | Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10 | 14.2.11. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн | Хамааралгүй заалт. | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах; | | | | |
| 3 | 4 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 19.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Гэр бүлийн үнэт зүйл”, “Гэр бүлийн харилцаа”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг нийт 1235 албан хаагч, иргэдийг оролцуулан зохион байгуулж, гэр бүлийн боловсрол олгож ажиллалаа. Нийт гэр бүлийн 8,3%-ийг хамруулсан.Нийт 9,865,000 төгрөг зарцуулсан байна. | 100 | | |
| | 5 | | 19.1.2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Нийгмийн бүлгүүдийн өмнө хуулиар үүрэг хүлээгчдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, хөгжил оролцоог дэмжих, хамтарсан багийг арга зүйгээр хангах, чадавхжуулах, зөвлөн туслах хүрээнд байгууллагын эцэг эхийн зөвлөл 250 гишүүн, , Хамтарсан багийн 82 гишүүн, нийт 332 хүнийг хамруулан хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг чадваржуулах зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгууллаа. Сургалтын төгсгөлд авсан сэтгэгдлээс харахад багшийн өгсөн агуулгыг сайтар ойлгож авсан, ажлын байран дээрээ очиж хэрэгжүүлэхээр ярьж байгаа нь сургалт өмнөө тавьсан зорилгодоо хүрсэн байна. Хамтарсан багаар үйлчилгээ хүргэх, баримт | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүрдүүлэхэд шаардлагатай анхаарах зүйлсийг дадлага ажилтай уялдуулан тайлбарласан. Кейс дээр ажиллахад үйлчилгээний үе шат бүрд анхаарч, түүнийг дасгал ажлаар бататгасан. Цаашид бөглөсөн маягт нь ажлын байран дээрээ очоод кейс дээр ажиллахад жишиг кейс файл болох бөгөөд үйлчлүүлэгчдэд кейс менежментийн үйлчилгээг үзүүлэхэд дөхөм болно. | | | |
| | 6 | | 19.1.4. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл 15 бүртгэгдсэнийг урьд оны мөн үетэй харьцуулахад 3.7 дахин өссөн, зөрчил 45 бүртгэгдсэнийг урьд оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 36.4 хувиар өссөн. хүүхэд оролцсон гэмт хэрэг 4 бүртгэгдэж 3 нэгжээр буюу 4 дахин, гэмт хэргийн улмаас 5 хүүхэд хохирсон нь 2 нэгжээр өссөн. Гэмт хэргийн холбогдогч, хохирогч хүүхдүүдэд шаардлагатай зөвлөгөө мэдээллээр үйлчилж, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. | 100 | | |
| | 7 | | 19.1.5. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ" гэж заасны дагуу аймгийн "Түр хамгаалах байр"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр /250 сая/ шинээр байгуулан, үйл ажиллагааг эхлүүлээд байна. 2024 оны 05 дугаар сарын байдлаар нийт 15 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ) | иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Үүнд бэлгийн хүчирхийллийн хохирогч 1, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 14 байна. Эрүүл мэндийн үзлэг 10, сэтгэлзүйн зөвлөгөө-13, зөвлөгөө ярилцлага 14 удаа хийж, өдөр бүр шинэ хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, кейс файлыг хааж ажилласан. | | | |
| | 8 | | 19.1.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Аймгийн Засаг даргын 01 захирамжаар 2024 оныг "Хүүхэд, Гэр бүл, хөгжил, хамгааллыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан жилийн ажлын төлөвлөгөө батлагдаж сум бүр хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах талаар үүрэг чиглэл хүргүүлж ажилласан. | 100 | | |
| | 9 | | 19.1.7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр "Монгол өрх" сэтгэлзүйн хүрээлэн, “Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжил дэвшил" ТББ, “Хүүхэд гэр бүл, хөгжлийн төлөө галт шувуу ТББ, Гэр бүл судлаач Ж.Баясгалан нартай хамтран, ажил гүйцэтгэх гэрээг байгуулж нийт 3 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 2,920,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон. Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголттой болсон. | 100 | | |
| | 10 | | 19.1.8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан | Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулсан “Та бол онцгой нэгэн” арга хэмжээний хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажилд идэвхтэй ажилласан 2 албан тушаалтныг Сайнцагаан сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 200,000 төгрөгөөр урамшуулан батламж гардуулсан. | | | |
| 4 | 11 | Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06 | 43.2.1. хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Шинэ хоршоо хөдөлгөөнд хэрхэн нэгдэх талаар Өндөршил, Дэрэн сумдын малчдын зөвлөгөөнд дээр сургалт зохион байгуулсан. Сайнцагаан сум Цэвэр шимт ургац хоршоо, Тод гэгээ урлал хоршоо, Хос эрдэнэ ундраа хоршоо, Цагаандэлгэр сум Цэгээн нуурын оргил хоршоо, Сайн сүүж хоршоо, Луус сум Залаа говийн шим хоршоо хоршоо байгуулагдсан. Одоогийн байдлаар 3 сумын 6 хоршоо байгуулагдаад байна. Цаашид “Малчдын хоршоо” байгуулах идэвх санаачилга нэмэгдэх хандлагатай байна | 100 | | |
| 5 | 12 | Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29 | 10.1. Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн | Аймгийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газар Дундговь-Ус ,Мандалын гэгээ ААТҮГ-ын гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж тогтоон мөрдөн ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно. | | | | |
| | 13 | | 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.) | УТХО-аар эрх шилжин хэрэгжиж буй 14 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулахаас одоогийн байдлаар 10 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулаад байна. | 70 | | |
| 6 | 14 | Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28 | 5.4. Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно. (5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын | Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/184 дүгээр захирамжаар сумдын баяр наадам болон түүхэн тэгш ойтой сумдын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хугацааг тогтоож сумдад хүргүүлсэн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.) | | | | |
| 7 | 15 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01 | 15.7. Согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно. | Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрхангай, Цагаандэлгэр, Гурвансайхан, Луус зэрэг 6 сумын 18 худалдааны газар, 3 зоогийн газар нийт 21 ААН-д тусгай зөвшөөрөл олгож орон нутгийн орлогын дансанд нийт 19.3 сая төгрөг төвлөрүүлсэн. Тус захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан өгч зөрчил дутагдал гаргуулахгүй байхад хэсгийн байцаагч, сумдын төлөөлөгч, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа нар тогтмол хяналт тавин ажиллаж байна.Тус захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан өгч зөрчил дутагдал гаргуулахгүй байхад хэсгийн байцаагч, сумдын төлөөлөгч, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа нар тогтмол хяналт тавин ажиллаж байна. | 100 | | |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| 8 | 16 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001-06-14 Дугаар 2001№57 | 2.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусган шийдвэрлэж байх. (Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баталсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.) | | | | |
| 9 | 17 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34 | 3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах; | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг Дундговь аймгийн хэмжээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 29-ны өдрийн хугацаанд 68 удаагийн сургалт мэдээлэлд 2170 хүн, алба сурталчлах 2 удаагийн өдөрлөгт 600 хүн хамруулж нийт 5399 иргэнийг дадлага сургалтад оролцуулан газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгосон. | 100 | | |
| | 18 | | 7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хурлаар 4 чиглэл 17 арга хэмжээтэй төлөвлөгөөг батлан хагас жилийн байдлаар хэрэгжилт 64 хувьтай ажиллаж хангагдаж байна. | 64 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 19 | | 8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх. | Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах байнгын ажиллагаатай дэд зөвлөлийг байгуулж, тус онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай хангагдаж, газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чадавх 14.3 хувиар нэмэгдсэн. | 90 | | |
| | 20 | | 1.5/. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах; | Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууцны барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлын судалгааг гарган, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж, дахин төлөвлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн 2019 оноос хойш Сайнцагаан суманд 2 сургууль, 2 цэцэрлэг нийт 4 барилгыг буулгаж, дахин төлөвлөн 150 ортой 1, 2-р цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулсан. Мөн 640 суудалтай Хүмүүнлэг сургуулийн барилга, 960 хүүхдийн суудалтай Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилга баригдаж байна. “Барилга байгууламжийг паспортжуулах, гэрчилгээжүүлэх” журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын дэргэдэх паспортжуулалтын дүгнэлтийг баталгаажуулах орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулсан. | 100 | | |
| 10 | 21 | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52 | 3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар | Аймгийн ИТХ-ын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 2024 онд аймгийн ОНХС-ийн нийт 7,531.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 төсөл арга хэмжээ, ОНХО-аар нийт 11,168.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 51 төсөл арга хэмжээ, Замын сангийн нийт 670.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 төсөл арга хэмжээ, Их засварын нийт 2,184.6 сая төгрөгийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх; | хөрөнгө оруулалтаар 10 төсөл арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн нийт 419.8 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 1,579.7 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулан хэрэгжүүлж байна. Дээрх арга хэмжээнүүд МУ-ын урт хугацааны БББ болон Алсын хараа-2050 болон улс аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн. | | | |
| 11 | 22 | МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72 | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | 2024 оны орон нутгийн төсөвт Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих “Нээлттэй-Дундговь” хөтөлбөр хэрэгжүүлэхээр 200.0 сая төгрөг батлуулсан. Мөн ЭЗХЯ-нд Говийн бүсийн ХАА-н үйлдвэрлэлийн ТЭЗҮ, зураг төсөв-1,000.0 сая, “Бага газрын чулууны аялал жуулчлал”-ын бүсийн ТЭЗҮ, зураг төсөв-1,000.0 сая, Түмний хорооллын гадна шугам сүлжээний ажлын зураг, төсөл-150.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээ батлагдаж ажлын даалгавар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэв. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 23 | | 1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | Аймаг болон сумын ОНХС-ийн санхүүжилтээр зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал батлуулж хэвшсэн бөгөөд 2024 оны аймгийн ОНХС-д тухайн зардал 437.5 сая төгрөг батлуулж улсын болон орон нутгийн төсвөөр ирэх онуудад хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж байна. | 100 | | |
| 12 | 24 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023-05-04 Дугаар 2023_32 | 1.3. төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх. | 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг байгуулж, зөвлөл хуралдаж 2024 оны төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 | | |
| 13 | 25 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2023-06-30 Дугаар 2023_59 | 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байгаа ба хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 01-ны дотор тооцон АТГ-т хүргүүлнэ. | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай. | | | | |
| 14 | 26 | МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93 | 1.2. хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх; | Өмнөх онд Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авснаар тус хорооллыг дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж эхлээд байна. Хаус хороолол төлөвлөсөн нийт 8 га талбайд цэвэр бохир, ус, халаалтад холбогдсон, хашаа, гарааштай орчин үеийн шийдэл бүхий 119 амины орон сууц байх юм. 2024 оны аймгийн ОНХС болон ОНХО-аар тус хорооллын гадна бохир усны шугамын ажилд 208.9 сая, гадна цахилгаан хангамж, дэд станц байгуулах ажилд 89.0 сая нийт 297.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Мөн Сайнцагаан сумын айраг баг, Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 0.4кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих ажилд нийт 498.6 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталснаар ойролцоогоор 1000 гаруй өрхүүд өмчилж авсан газартаа амьдрах орчин бүрдэж байна.2024 оны аймгийн хөрөнгө оруулалтаар Дэрэн болон Хулд сумын төрийн албан хаагчдын байрны засварт 821.1 сая төгрөгийг батлаад байна. | 100 | | |
| | 27 | | 1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх | | ХБ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах; | | | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 15 | 28 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ | 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик иругүлэх) | Нийт аймгийн хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний 30,6% БЗДХӨ, 8,2% сүрьеэгийн өвчлөл эзэлж байна. Хагас жилийн байдлаар сүрьеэгийн 12, БЗДХӨ-ий 41 тохиолдол шинээр бүртгэгдэж 100% эрүүлжүүлж байна.Сүрьеэгийн эрт илрүүлэлт, сорьц тээвэрлэлтийг 4 сумаас 16 хүний 32 сорьцыг тээвэрлэсэн байна. Сорьц тээвэрлэх эрт, илрүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 3 сарын болзолт уралдааныг 05 дугаар сарын 06-ний өдрөөс эхлэн 08 дугаар сарын 06-ний хооронд зарлаж удирдамжийг хүргүүлээд байна. Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран дэмжлэгт хяналт болон үзлэгийг 7 сумын сүрьеэгийн хяналтад байгаа 157 хүнийг үзлэгт, шинжилгээнд хамруулллаа. Үзлэгээр цэрний түрхэц авах 10, сүрьеэгийн далд халдвар илрүүлэх сорилыг 10 иргэнд тус тус авахаар лавлагаа шатлалын эмнэлэг рүү илгээлээ. Сүрьеэгийн хавьтлыг илрүүлэх үзлэгт нийт хамрагдвал зохих 27 хавьтлаас 24 хавьтал хамрагдаж 88,8 хувийг хамруулсан байна. | 100 | | **төсөв УТХО 2,3** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 29 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ | 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; | Улсын жилийн төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэгт тусган хэрэгжүүлж тайлангийн хэрэгжилт 90 хувьтай байна. Тэмбүү, ДОХ/ХДХВ шинжилгээг 854 хүнд хийснээс урьдчилан сэргийлэх 510, хяналтын давтан шинжилгээнд 110, сайн дураараа шинжилгээ 234 хүн өгсөн байна. Тэмбүүгийн халдвар 14 илэрч 100% эмчилгээнд хамруулан хяналтад авч ажиллаж байна. ХДХВ/ДОХ болон тэмбүү илрүүлэх шинжилгээнд давхардсан тоогоор 1824 жирэмсэн эх хамрагдаж, шинжилгээнд хамрагдалт 89.5 хувь байна. Шинжилгээгээр тэмбүүгийн эерэг тохиолдол 2 илэрснээс эдгэрэлтийн хувь 100, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй. | 100 | | |
| | 30 | | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгаанд улсын төсвийн 11,0 сая төгрөг, Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын үзлэгийг эрчимжүүлэх улсын төсвийн (ЭМДС) 186,8 сая төгрөг, Зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, болон халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт улсын төсвийн 71,6 сая төгрөг, Халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх товлолд болон нэмэлт дархлаажуулалтад улсын төсвийн 199,2 сая, орон нутгийн төсвийн 52 сая төгрөг, Сумдын эрүүл мэндийн төвийг мобайл технологиор хангах улсын төсвийн 15,2 сая төгрөг, ДЭМБ 76,8 сая төгрөг зэрэг хүн амын мэндийг дэмжих хамгаалахад зориулан зарцуулаад байна. | 100 | | |
| 17 | 31 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | | | | |
| 18 | 32 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ | 3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах | Аймгийн хэмжээний 19 сургуулийн 17 сургууль тус бүр 15-20 сая төгрөг буюу нөхөн хангалтын зардлын нийт 255,2 сая төгрөг бүхий wifi төхөөрөмжийн багцын худалдан авалт хийж сургууль, дотуур байрны орчинд тоног төхөөрөмжийн суурилуулалтыг шинээр хийж, анги давхарт хүртээмжтэй тараах ажлыг зохион байгуулснаар интернэт хангалт 89,4 хувь болж өмнөх оноос 37,5 хувиар сайжирсан байна. Цахим ангиудад 394 ширхэг таблет, 172 ширхэг chromebook, 28 ширхэг ухаалаг самбар, 66 ширхэг ухаалаг телевиз зэрэг тоног төхөөрөмжийг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулж 19 сургуулийн 17 буюу 89,4 хувь нь цахим танхим бий болгох орчин, тоног төхөөрөмжийг бүрдүүлсэн бол иж бүрэн тоног төхөөрөмж бүхий тусгай цахим танхимыг 7 сургууль байгуулаад байна. Үүний үр дүнд eduten, pearson хөтөлбөрийн цахим хичээлүүд болон бусад цахим платформыг сургалт тасалдалгүй явагдаж байна. 2024 онд Хүмүүнлэг, Говийн Ирээдүй сургуулиуд орон нутгийн 260,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахим ангийн тендер зарлагдаад байна. | | | |
| 19 | 33 | Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ | 1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх; | | | | |
| | 34 | | 1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйл ажиллагаа сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх; | | | | |
| 20 | 35 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ | 1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх; | Говийн Ирээдүй цогцолбор сургуулийн 960 хүүхдийн багтаамжтай шинэ сургуулийн барилгын ажилд 2024 онд 4,454.3 сая төгрөг, Хүмүүнлэг сургуулийн 640 хүүхдийн багтаамжтай шинэ сургуулийн барилгын ажилд 7,636.5 сая төгрөгийг суулгуулж барилгын ажил хийгдэж байна.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчны стандартын шаардлагад нийцүүлэн Адаацаг сумын сургуулийн хоол үйлдвэрлэлийн хэсэгт ОНТ-өөс 20 сая төгрөгийн засвар хийснээр хоол үйлдвэрлэлийн орчин болон агааржуулах системийг сайжруулж хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжрууллаа. Цагаандэлгэр сумын сургуулийн хоол үйлдвэрлэлийн хэсгийг төвийн шугамд холбосноор эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулсан байна. Сайнцагаан сумын 2-р цэцэрлэг, Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн 150 хүүхдийн багтаамжтай шинэ цэцэрлэг ашиглалтад орсноор стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн хэсэгтэй болоод байна. Өмнөх онд стандартын шаардлага хангасан 32 хоол үйлдвэрлэлийн хэсэг байснаас хагас жилийн байдлаар нийт 36 болж шинээр 4 сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчин, үйл ажиллагааны чанар, эрүүл ахуй, аюулгүй байдал сайжирсан байна. Стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн эзлэх хувь 90 байна. | 100 | | |
| | 36 | | 1.9/. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд | Адаацаг, Өлзийт, Дэлгэрцогт, Хулд, Дэлгэрхангай сумдын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээний чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагааг 2-3 удаа зохион байгуулж хоолны цэс | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн хяналтын байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах; | төлөвлөлт, технологи картын боловсруулалт, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, аюулгүй байдал, өдөр тутмын хөтөлгөө, технологийн урсгал, мэдээллийн самбарын баяжуулалт, хоолны ордерын бичилт, хүнсний агуулахын эрүүл ахуй, бүтээгдэхүүний хадгалалт зэрэгт хяналт тавьж ажилласны үр дүнд хоолны цэсийг 14 хоногоор төлөвлөх, технологийн картын боловсруулалтад зөвлөгөө өгч сайжруулалтыг хийж дахин боловсруулах, өдөр тутмын хоолны дээжийг тогтмол авах, хадгалах хугацааг тодорхой байдлаар тэмдэглэж байх, хоолны ордерыг өдөр бүр хянаж баталгаажуулах зэрэг зөвлөмжийн дагуу 2 удаа хугацаатай албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. ЭМГ-ын эрүүл ахуй, халдвар хамгаалал хариуцсан байцаагчтай хамтран Сайнцагаан сумын сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байгаа нөхцөл байдалд хяналт тавьж 2 сургуульд албан шаардлага хүргүүлж худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг зогсоолоо.Албан бичиг хүргүүлсэн боловч нэг сургууль зориулалтын бус орчинд хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулснаас үүдэн хадгалалтын хугацаа, горим алдагдсанаас болж суралцагчийн эрүүл мэндэд өөрчлөлт орж гүйлгэсэн тохиолдол илэрч уг асуудлыг ХХААГ-ын Хүнс хоол үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын улсын байцаагчид мэдэгдэж худалдаа эрхлэгч ААН болон сургуулийн удирдлагуудад сануулах болон торгуулийн арга хэмжээг авч дахин худалдаа, үйлчилгээ үзүүлэхийг хориглон таслан зогсоолоо. | | | |
| | 37 | | 1.10/. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний | Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион | 50 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх; | байгуулах ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийн тайланг нэгтгэхэд 40 байгууллагаас 32 байгууллага тендер зарлаж үүнээс 21 байгууллагын тендерт аж ахуй нэгж, байгууллага шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. | | | |
| | 38 | | 1.11/. 2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх. | Төсвийн төслийг хугацаанд нь хүргүүлж тусгаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08 сарын 31-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор “Сүү” хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна. “Сүү” хөтөлбөрт 15 сумын 18 сургуулийн бага ангийн 4457 суралцагчдыг хамруулж, аймаг, сумын засаг дарга, эцэг эх хамтран 92 сая төгрөгийн санхүүжилт хийгээд байна. Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 9-12 сарын санхүүжилтийн зарцуулалт 95 хувийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны 1 сараас 5 сар хүртэл 18 сургуульд 137 сая төгрөг зарцуулагдахаас одоогийн байдлаар 18 сургуулийн 99 сая төгрөг зарцуулагдсан буюу 69.5 хувийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Дундговь аймгийн Засаг даргын А/167 дугаар захирамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 15 сумын 22 цэцэрлэгийн 3500 хүүхдийн хамруулан “Сүү хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлээд байна. Цэцэрлэгийн сүү хөтөлбөр 60 мл-ийн хэмжээтэйгээр ажлын 5 өдрийн 3 өдөрт бага үдийн цайны цагаар олгож байна. Аймгийн нийт 22 цэцэрлэгийн хүүхдийн сүүний мөнгөнд 4, 5 сард 22.7 сая төгрөг зарцуулагдахаас хагас жилийн байдлаар 14.7 сая төгрөгийг буюу 64.7 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хувийн гүйцэтгэлтэй байна. “Хүүхдийн шим тэжээлт хоол - хоёрдугаар уралдаан”-ыг 2024 оны 04 сарын 21-ний өдөр зохион байгуулж нийт 6.6 сая төгрөгийг ОНТ-өөр санхүүжүүлэн зохион байгууллаа. | | | |
| 21 | 39 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ | 1.1/. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах; | Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “Эрүүл Монгол”, “Эрүүл чийрэг Дундговьчууд” аяны хүрээнд аймгийн хэмжээнд 15 сум, 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр давхардсан тоогоор нийт **25295** иргэн нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэсэн. Өглөөний алхалт, зөөлөн гүйлт, дугуй унах, дасгал, бүжиг, явган аялал, спортоор хичээллэх, нийтийг хамарсан спортын арга хэмжээнд нийт 8638 иргэн хамрагдаж, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх нийтийн биеийн тамир, спортоор хичээллэж байна. Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлын хүрээнд Үндэсний сурын харваа тэмцээнийг 3 удаа, өвлийн харваа тэмцээнийг 1 удаа, үндэсний бөхийн барилдааныг 3 удаа, үндэсний шагайн харваа тэмцээнийг 3 удаа, Хаврын бүсийн морин уралдаан 1 удаа тус тус зохион байгуулсан. Мөн хүүхэд багачуудын дунд үндэсний спортыг хөгжүүлэх өвлүүлэн уламжлуулах зорилгоор ОУХЭХ өдөр буюу 06 дугаар сарын 01-нд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд “Хуйрнан шуугигч” бөхийн барилдаан, сургуулийн насны хүүхдүүдийн дунд анх удаа “Үндэсний шагай”-н харваа тэмцээнийг зохион байгуулсан нь хүүхэд багачууд үндэсний спортоор хичээллэх хүсэл сонирхолтой болж тамирчдын тоо өсөн нэмэгдэж байна. Орон нутгийн төсвөөс 4,840,000, Улсын төсвөөс 12,744,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 | | Орон нутгийн төсвөөс 4,840,000, Улсын төсвөөс 12,744,000 төгрөгийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 40 | | 1.5/. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Дундговь аймгийн хэмжээний 19 сургуулийн 36 багш 2024 оны эхний хагас жилд 57 төрлийн секц дугуйланд 2452 сурагчдыг хамруулан тэмцээн уралдаануудад амжилттай оролцуулж ажиллаад байна. Биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүн 407 төрлийн хэрэглэгдэхүүнийг 10,4 сая төгрөгийн хичээл практикийн зардлаар нийлүүлэгдсэн нь өмнөх оны биеийн тамирын хичээлийн кабинетын тохижилт үйлчилгээ, хичээлийн хэрэглэгдэхүүний тоог нэмсэн 11 сургууль байгаагаас кабинетын шаардлага нэмж хангасан 3 сургууль байна. Нийт 18 сургууль кабинеттай болоод байна. | 100 | | |
| | 41 | | 1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | БТСГ-ын дасгалжуулагч О.Буянтогтох нь Бүгд Найрамдах Хятад Ард улсын Бээжин хотод болох “Биеийн тамир, спортын салбарын төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх сургалт”-д 14 хоног хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлж ирсэн. Улсын төсвөөс 0.7 сая төгрөгийг зарцууллаа. | 100 | УТ-0.7 | |
| | 42 | | 1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг | Усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг 2023 онд улсын төсвийн дөрвөн тэр бум наян хоёр /4.82.0/ сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэлийг “Жи жи ай” ХХКомпани нэг давхрын карказ, суурийн дүүргэлт зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна. 2024 оны ажлын гүйцэтгэл 80 хувьтай, нийт барилгын гүйцэтгэлийн ажил 70 хувьд хүрсэн байна. | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. | | | | |
| 22 | 43 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ | 1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Говийн нөхцөлд үр тариа тариалдаггүй тул энэхүү заалт хэрэгжих боломжгүй, хасуулах хүсэлтэй байна. | 0 | | |
| | 44 | | 1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор | Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжийн зориулалтаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 179.5 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлд хамрагдаж 10*30=300м.кв хүлэмжид хүнсний нарийн ногоо тариалж одоогийн байдлаар 0,35 тн өргөст хэмх хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлээд байна. Сайнцагаан сумын Арвин их сан ХХК жимс, жимсгэнийн тариалалтын зориулалтаар 210.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлд хамрагдсан 3 га талбайд алимын төгөл байгуулах зорилгоор, 4 төрлийн сортын алимын суулгац тариалсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал"-ын талаар авах зарим арга хэмжээний | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд улсын төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн 3 га талбайд жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн плантаци төв байгуулсан. Үржүүлгийн төвд улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс, жимсгэнийн суулгац 1500, нийт 2375 ширхэг суулгацыг суулган хүлээн авч, арчилж, усалж ургуулж байна. Нийт модны ургалт 50 хувьтай. Сайнцагаан сумын иргэн С.Амарбаясгалан Бүгд найрамдах солонгос улсын технологиор барьсан 3 улирлын 280*4=1120м.кв хүлэмжид эрт ургацын байцааг тариалж, одоогийн байдлаар 6тн байцааг ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлээд байна. Дээрх 3 улирлын хүлэмжийг хувийн хөрөнгө оруулалтаар буюу 250,0 сая төгрөгөөр барьж байгуулсан.Сайнцагаан сумын иргэн Ч.Ихбаяр нь хувийн хөрөнгө оруулалтаар 110,0 сая төгрөгөөр шинээр 3 га- талбайг хашаажуулж, Зуны 4 ш буюу 1400 м.кв талбай бүхий хүлэмжийг /(7*50=350м2)*4=1400м2/ барьж байгууллаа.Дээрх хүлэмжүүдэд тарвас, лооль, өргөст хэмхийг тариалсан. 2,3 га ил буюу гадаа талбайд эрдэнэ-шиш тариалах бэлтгэл ажил хийгдэж байна. | | | |
| 23 | 45 | "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын | 1.1/. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БСШУСБХ | тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх; | | | | |
| | 46 | | 1.2/. төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах; | | | | |
| | 47 | | 1.3/. төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох; | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 48 | | 1.4/. захиалагчаас тогтоосон нөхцөл, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу 2022 оны 4 дүгээр сард багтаан тус тус сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлэн гүйцэтгэлд хяналт тавих; | | | | |
| | 49 | | 1.5/. тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгох; | | | | |
| | 50 | | 1.6/. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх. | | | | |
| 24 | 51 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга | 1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ | тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах; | | | | |
| | 52 | | 1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох; | | | | |
| | 53 | | 1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | | | |
| | 54 | | 1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах; | | | | |
| 25 | 55 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | 15 суманд ахмадын өргөө, аймгийн төвд Ахмадын ордонтой болсон. Ахмадын хорооны үйл ажиллагааны зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгадаг бөгөөд 2023 онд 101.8 сая, 2024 онд 136.2 сая төгрөгийн төсвийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулаад байна. Ахмадын хорооны үйл ажиллагаанд эхний хагас жилд 73783,4 мянган төгрөг зарцуулсан.<br><br>Ахмадын ордны тоног төхөөрөмж нийлүүлэх Улсын төсвийн 180,0 төгрөгийн өртөгт тендерт Мээжийн хишиг ХХК шалгаран тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. | 100 | | |
| 26 | 56 | Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ | 1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх | | | | |
| 27 | 57 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ | 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах; | | | | |
| 28 | 58 | Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ | 1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус | Ид шидийн орон, сургуулийн 4 сэтгэлзүйчтэй хамтран “СЭТГЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ” нээлттэй өдөрлөгийг Политехник коллеж, сумын ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгууллаа. Анги хамт олны уур амьсгалыг эерэгжүүлэх бүлгийн сургалтад 944 сурагч, “Сэтгэл хөдлөлөө удирдах нь” лекцэд 547 сурагч 1491 хүний хамруулллаа. Миний сэтгэл хөдлөл” бүлгийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээг авах нөхцөлөөр хангах; | сургалтад 45 эцэг эх, Ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөөнд 3 эцэг эх, нийт 48 эцэг эх хамрагдлаа Мөн хүүхдийн тусламжийн 108 утасны чат ботын ажиллуулж байна. | | | |
| | 59 | | 1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах; | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс ХГБХХГ-ын тусгайлан бэлдсэн охидын өрөөнд ганцаарчлан ярилцлага хийдэг. Цагдаагийн газар болон хохирогч болон сэжигтнээр байцаагдаж байгаа 7 хүүхдэд хууль ёсны төлөөлөгч томилж ажиллуулсан. Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байх зарчмыг баримтлан ажилласан. | 100 | | |
| | 60 | | 1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх; | Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс санаачилсан Өв соёлоо түгээн дэлгэрүүлцгээе", Чадавхжуулах сургалт, "Архи үгүй амьдрал-Аз жаргал" аян, Рубик шоо – спорт өрөлтийн тэмцээн, Өсвөрийн парламентийн хөтөлбөр зэрэг 5 арга хэмжээнд 200 гаруй оролцогчдыг хамруулан тус үйл ажиллагаагаар ерөнхий боловсролын сургууль, аймгийн хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж хамтын ажиллагааг сайжруулж ажилласан. Тус үйл ажиллагаанд улсын төсвөөс 3.2 сая төгрөг зарцууллаа. | 100 | улсын төсвөөс 3.2 сая | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 61 | | 1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах; | Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын жилийн ажлын хүрээнд Хүүхэд, гэр бүлийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн идэвх оролцоог сайжруулахаар eMongolia программын ekids апплейкэйшн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Цахимаар хамгаалъя” арга хэмжээг Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Дундговь аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгууллаа. Тус нөлөөллийн арга хэмжээгээр цахим үе тэнгийн дээрэлхэлд,-E-Kids -Google family link, ”Цахимаар хамгаалъя” уриатай зурагт самбар аялуулсан. Тус үйл ажиллагаанд улсын төсвөөс 70.000 төгрөгийг зарцуулсан. | 100 | УТ-70.0 | |
| | 62 | | 1.2.4/. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах; | Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хамтарсан ажлын хэсэг 2023 оны 05 сард ирж 2017-2022 оны санхүүгийн баримтад иж бүрэн үзлэг шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал байхгүй. | 100 | | |
| | 63 | | 1.2.6/. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх. | Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийн хэрэгжилтийн хүрээнд батлагдсан хөтөлбөр, агуулгын дагуу Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх сунгах сургалтыг зохион байгуулагдсан. Тус сургалтад ХГБХХГ-ын Хүүхдийн эрхийн улсын байцаагч Ш.Эрдэнэсувд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ. Тус ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн улсын байцаагч Ш.Эрдэнэсувд Хаан банк, Хас банк, Төрийн банк, Номын сан, Хүнс, хөдөө аж ахуйн газар, 2 цэцэрлэг, Ахмадын хороо 7 байгууллагад Зөрчлийн тухай хууль, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүүхдийн эрх, хамгаалал иргэдийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оролцоо гэсэн агуулгын хүрээнд сургалтуудыг зохион байгуулсан.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь 15 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, Гүйцэтгэлийн хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. | | | |
| 29 | 64 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ | 6в/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлэх, Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга /С1оЬа1 1пШайуе Тог Е\|вса1 Тгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зарчмуудыг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох; | | | | |
| | 65 | | 6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | | | | |
| 30 | 66 | Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10 | 1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх; | Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн дагуу албан хаагчдыг ажилд томилж, ёс зүйн зөрчил гаргаж байсан иргэнийг төрийн албанд томилохгүй байх зарчмыг баримтлан хууль журмын дагуу сонгон шалгаруулж мөрдөн ажиллаж байна. | 100 | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 31 | 67 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгааг 2 бичгээр бичих чиглэлийг аймгийн Засаг даргын 2024 оны 458 дугаар албан тоотоор бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг 6 сарын 25-ны дотор нэгтгэн хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлэхээр ажиллаж байна. Аймгийн Засаг даргаар батлуулсан үндэсний бичгийн анхан, дунд шатны болон цахим бичвэрийн 3 модуль сургалтын хөтөлбөрийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага болон 15 сумдын төрийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад хүргүүлж, ерөнхий боловсролын 19 сургуулийн монгол хэл бичгийн 50 багш үндэсний бичгийн сургалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, энэ 2024 оны эхний хагас жилд шинээр 332 албан хаагч гэрчилгээгээ гардан авч, нийт 3121 албан хаагчид сургалтад хамрагдсан нь хүрэх түвшнээс 178 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Монгол | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн “Ням” гаригийг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдөр болгон тэмдэглэх шийдвэрийн хүрээнд арга хэмжээг 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний 1, 2-р үе шатанд аймгийн 15 сумын хүүхэд багачууд, анги хамт олон, төрийн албан хаагчид, иргэдийн төлөөлөл, аймгийн удирдлагууд, аймгийн болон Сайнцагаан сумын хэлний бодлогын салбар зөвлөлийн гишүүд, аймгийн төвийн монгол хэл, уран зохиолын багш нар, Сайнцагаан сумын сургуулийн удирдлагууд, Политехник коллежийн удирдлага, багш нар нийт 1943 хүн оролцлоо. Үндэсний бичиг үсгийг угтан дараах арга хэмжээг зохион байгуулсан нь олны талархлыг хүлээлээ. Үүнд: “Бийрийн хэлхээ-2024” уран бичлэгийн уралдаан”-д 7-12-р ангийн 7 сургуулийн 55 суралцагч, ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын үндэсний бичгээр хурдан зөв унших чадварыг хөгжүүлэх “Тэргүүний уншигч” уралдаанд 9 сургуулийн 49 суралцагч, “Төрийн албан хаагчдын их сорилго”-д 142 төрийн албан хаагчид, “Төрийн албан хаагчдын цахим бичвэр” уралдаанд 63 төрийн албан хаагчид, “Үндэсний бичгийн тээгч, түгээгч” арга хэмжээнд 9 сумын нийт 18 иргэд тус тус амжилттай оролцов. Мөн үндэсний бичгийн хичээлийн хоцрогдлыг анги нийтээр нь арилгах, нөхөх, сургалтын чанарыг ахиулах зорилгоор Мандал сургуулийн зохион байгуулсан 7-р ангийн анги нийтийн олимпиадад 19 сургуулийн нийт 31 бүлгийн 709 суралцагч, 11-р ангийн 18 бүлгийн 457 суралцагч 2 удаагийн сорилд тус оролцлоо. Тоон үзүүлэлтийг нэгтгэн үзэхэд энэ онд аймгийн 15 сум, төрийн байгууллагын 777 иргэн, төрийн албан хаагч оролцсон нь өмнөх оны мөн үеэс 454-өөр, | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | санхүүжилт, 7.5 сая буюу 2.0 сая төгрөгөөр нэмэгдсэн сайн үзүүлэлттэй байна. | | | |
| 32 | 68 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.16.Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих | ЭМГ-ын эрүүл ахуй, халдвар хамгаалал хариуцсан байцаагчтай хамтран Сайнцагаан сумын сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байгаа нөхцөл байдалд хяналт тавьж 2 сургуульд албан шаардлага хүргүүлж худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг зогсоолоо.Албан бичиг хүргүүлсэн боловч нэг сургууль зориулалтын бус орчинд хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулснаас үүдэн хадгалалтын хугацаа, горим алдагдсанаас болж суралцагчийн эрүүл мэндэд өөрчлөлт орж гүйлгэсэн тохиолдол илэрч уг асуудлыг ХХААГ-ын Хүнс хоол үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын улсын байцаагчид мэдэгдэж худалдаа эрхлэгч ААН болон сургуулийн удирдлагуудад сануулах болон торгуулийн арга хэмжээг авч дахин худалдаа, үйлчилгээ үзүүлэхийг хориглон таслан зогсоолоо. | 100 | | |
| 33 | 69 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, | 2024 оны орон нутгийн төсөвт уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг, агаарын бохирдлыг бууруулах, байгаль хамгаалах нөхөн сэргээх, хөтөлбөр арга хэмжээний зардалд нийт 680,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймгийн иргэдийн хурлаар батлуулан төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021 оноос “Дундговио ногооруулъя” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж 2020 онд аймгийн хэмжээнд 221,640 ширхэг мод тоологдсоныг 2021-2024 онд 1 дахин нэмэгдүүлж 404,025 ширхэгт хүргэсэн байна. 2020 онд 369,4 га байсан ногоон байгууламжийн хэмжээг сүүлийн 4 жилд 80,1 га-р нэмэгдүүлж 449,5 га-д | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах | хүрсэн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд энэ онд өвөл , зуны 125 ш хүлэмжид буюу 15999 м2 талбайд тариалалт хийсэн байна. Одоогоор сумын 1 ААН, 2 иргэд 2080 м2 өвлийн хүлэмжид тариалалт хийж, Одоогоор өргөст хэмх -1,3 тн, хулуу -1,1 тн ургацыг тус тус хурааж нийт 2400 тн-ийг орон нутгийн зах зээлд нийлүүлээд байна. | | | |
| | 70 | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | "Дундговио ногооруулъя" үзэсгэлэн худалдааг 3 дахь удаагаа зохион байгуулж 11 иргэн, аж ахуйн нэгж өөрсдийн бүтээгдэхүүнийг сурталчлан оролцсон ба хүнсний ногооны 13 төрлийн үр үрсэлгээ, 4 төрлийн шингэн болон хуурай бордоо, 7 төрлийн жимсний мод, 6 төрлийн навчит, 2 төрлийн шилмүүст модны тарьц суулгац, тасалгааны болон мандлын цэцгийн үр, 35 нэр төрлийн багаж хэрэгсэл, хүлэмжийн тоног төхөөрөмжийг танилцуулан, худалдаалж, мэргэжлийн байгууллагууд шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөмж үйлчилгээг нийт 600 иргэнд үзүүлэв. Орон нутгийн онцлогт тохирсон, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн хүрээг тэлэх, ногоочдын мэдлэг чадварыг сайжруулах, жимсний мод тарих, өвөлжүүлэх арга технологийг түгээх зорилгоор “Газар тариалан, хүлэмж, хөдөө аж ахуй, жимсний мод тарьж ургуулах, өвөлжүүлэх агротехнологийн сургалтыг" Ногоон- | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ази" ТББ-ын зөвлөх Ким Сон Чольтой хамтран зохион байгуулж 15 сумын 66 тариаланч, төрийн байгууллагын 54 албан хаагчийг хамруулав. Сайнцагаан сумын “Ахмадын төгөл”-д 0,1 га-д 644 мод, зүлэг бүхий тохижилттой цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулав. Орон нутгийн төсвийн 132 сая төгрөгийг зарцуулав. “Дэлхийн ойн өдөр”-ийг угтан “Дундговио ногооруулъя” үзэсгэлэн зохион байгуулж, 600 иргэн оролцсон. 10 богино, 7 видео бичлэгийг хийж олон нийтийн сүлжээнд иргэдэд сурталчилж, төв зам дагуу “Айл бүр хашаандаа мод тарья” уриалга бүхий баннер хийж байршуулсан. | | | |
| | 71 | | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутаг руу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | Гурвансайхан сумын Их газрын чулууны ууланд Баян-Уул, Ерлөг ууланд 2 цэгт зэрлэг амьтан ундаалах хөв цөөрөм байгуулахаар ажлын даалгавар боловсруулан тендер зарлаад байна. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Эрдэнэс алт ресурс" ХХК, "Болор жонш" ХХК-ууд баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашигласан усаа 85 хувьтай цэвэршүүлэн, цэвэрлэсэн усныхаа 70% -ийг дахин ашиглаж байна. "Дундговь-Ус" ОНӨҮГазрын 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 400м3/хоног бохир усыг 90%-тай цэвэршүүлж байна. Цэвэршүүлсэн усыг ногоон байгууламж, тэжээлийн ургамлын усалгаанд ашиглахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. “Дундговь” ХХК-тай гэрээ байгуулж Өлзийт сумын “Сүүжийн булаг”, “Баруун билүүний булаг”, Сайхан-Овоо сумын “Өвөр булаг” нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гэрээ байгуулсан. | 100 | | |
| | 72 | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан | "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", "Дундговио ногооруулъя хөтөлбөр"-ийн хүрээнд Аймгийн ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030” төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 60 дугаар | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх | тогтоолоор 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг батлуулан 70 хувьтай хэрэгжүүлсэн. Тайвань улсын хөрөнгө оруулалтаар дахин боловсруулсан цаасны целлюлозыг ашиглан хийсэн мод усалгааны эко хувинтай модыг Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт тарьсан. Эко хувингийн тусламжтайгаар модны суулгацыг нэг сарын турш ус чийгээр бүрэн хангах боломжтой. 2024 оны сумдын тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламжийн зориулалтаар 7 сум 331.89 га, мод үржүүлгийн зориулалтаар 3 сум 52.52 га, нийт 384.41 га газрыг тусган батлуулсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговио ногооруулъя” хөтөлбөр, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 298 аж ахуйн нэгж, байгууллагын 1610 иргэн 118527 мод, сөөгийг тарьж цэнэг усалгаа хийж, нийт модны тоо 401936-д хүрэв. Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувь 2.3 хувиар нэмэгдэж 13.8 хувьд хүрэв. | | | |
| 34 | 73 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | Аймгийн 17 спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох тамирчдад эрхийн төлбөр, байр, хоол, унааны зардал, бэлтгэл, сургалт явуулах заал танхимаар ханган үйл ажиллагаанд нь 18.500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран “Sport time” арга хэмжээг 7 хоног бүрийн 5 дахь өдөр 15:00-17:00 цагийн хооронд иргэд, хүүхэд, залуучуудын дунд 9 төрлөөр зохион байгуулсан уг арга хэмжээнд давхардсан тоогоор 150 гаруй тамирчид оролцсон. Арга хэмжээг зохион байгуулснаар хүүхэд, залуучууд дуртай спортоороо хичээллэх, өөрсдөө баг бүрдүүлэн тэмцээнд оролцох, бие биедээ зааж сургах боломжийг бүрдүүлж өгч байгаагаараа давуу талтай байсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 74 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Цагаандэлгэр, Хулд сумын соёлын төвөөс Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хэрхэн дээдлэн шүтэж, иргэдийг уриалж байгаа тэргүүн туршлагыг 4 соёлын төвд түгээж, хэрэгжүүлэх ажлыг Соёл, урлагийн газраас уриалж, зохион байгууллаа. “Соёлын өв” улсын уралдаанд аймгаас шалгарсан 2 сурагчид 50000 төгрөгийн үнэ бүхий Чингис хааны түүхийг бичсэн 2 календарийг шагналд өгч урамшуулан, дээдлэн шүтэж байхыг уриаллаа. Монгол гэр үзэсгэлэнгээр “Дуу хуурын өргөө”, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр зохион байгуулсан “Соёлын өвийн өртөө” дамжуулан Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залж дээдлэн шүтэж байхыг нийт 11750 иргэнд уриаллаа. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан. | 100 | | |
| | 75 | | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Аймгийн хэмжээнд эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залах талаар өнгөрсөн 2023 онд чиглэл өгснөөр төрийн 23 байгууллага, цэцэрлэг, сургууль нийт 41 байгууллага 100 хувь эш хөргийг залан өсвөр үе хүүхэд багачуудад дээдлэн шүтэх талаар нийгмийн ухааны хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар сурталчилж байна. | 100 | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 36 | 76 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай | 1. Хот, сууринуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын | Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ашиглалтын шаардлага хангахгүй болсон талаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу Сайнцагаан сумын 7-р багийн 1,2-р байрны оршин суугчдад тус 2 | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2010-03-18 Дугаар 2010_10/09 | шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, | барилгыг буулгаж дахин төлөвлөх хүсэлт гаргасан. Тус хүсэлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тус 2 барилгыг буулгаж 0.3 га газрыг дахин төлөвлөлтөд оруулахыг дэмжсэн тогтоол гарч дахин төлөвлөлтийн төсөл боловсруулагдаж байна. | | | |
| | 77 | | 3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх, | Иргэдэд газар хөдлөлтийн аюулыг таниулах, болзошгүй эрсдэлийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг олгох зорилгоор Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумын 160 иргэнд “Бэлэн бай” танхимын сургалтыг зохион байгуулсан. Мөн 4 цэцэрлэгийн 120 хүүхдийг хамруулан танхимын үлгэрчилсэн сургалт зохион байгуулсан. “Говийн баавгай” өртөөчилсөн сургалтад Сайнцагаан сумын Мандал сургуулийн бага ангийн 160 сурагчийг хамруулан гал унтраагуур ашиглах, what3words апп ашиглан байршлаа мэдээлэх, анхны тусламж үзүүлэх, газар хөдлөлтийн үед аврах ажиллагаанд оролцох талаар анхан шатны мэдлэг олгосон. Орон нутгийн гамшгаас хамгаалах 12 алба, сумын болон тусгай зориулалтын 33 мэргэжлийн ангийн 1230 алба хаагчдад газар хөдлөлтийн гамшгийн үед бэлэн байдлыг хангах, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах тухай цахим сургалтыг зохион байгуулж, дадлага сургуульд оролцох бэлтгэлийг хангуулсан.<br>Хулд сумын Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн 60 сурагчдын дунд “Хэн ч хэзээ ч хаана ч бэлэн” буухиа тэмцээнийг зохион байгуулж, онцгой байдлын албаны үйл ажиллагаа, аврагч гал сөнөөгч нарын ажил мэргэжлийн онцлог, үүргийг сурталчлан ажилласан. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гамшгийн аюулын тухай | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зарлан мэдээллийн дохиогоор ажиллах бүх нийтийн дадлага сургуулийн тухай мэдээллийг төрийн 40 байгууллага, 20 аж ахуйн нэгжид танхимын сургалт зохион байгуулж, 660 ажилтанд зөвлөмж мэдээлэл хүргэсэн. | | | |
| 37 | 78 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх. | Тус аймгийн хэмжээнд ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох тухай шийдвэр гаргаагүй байна. | 0 | | |
| 38 | 79 | Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 | 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх | БОАЖГ аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо ГҮТББ-тай хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Эко жорлон” арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 15 сумын удирдлагууд, төрийн албан хаагч, иргэд 120 хүнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийн талаар сургалт зохион байгуулсан. Мөн “Эко жорлон” үзэсгэлэнгээр хуурай технологийн 8 төрөл, электрон ухаалаг нэг, ус хэмнэлтийн хуйлруулагч хошуу бүхий 2 төрөл, соруулдаг нүхэн жорлонгийн 1 төрөл нийт 13 төрлийн жорлонгийн танилцуулга, үзэсгэлэнг 200 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 2024 онд шинээр стандартын шаардлага хангасан 5 ариун цэврийн байгууламж нэмэгдэж аймгийн хэмжээнд эко ариун цэврийн байгууламжийн тоо | 90 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 156 болж нэмэгдсэн. Банкны ногоон зээлээр бага оврын цэвэрлэх байгууламж авч ашиглаж буй иргэний ариун цэврийн байгууламжийг сурталчлах мэдээлэл бэлтгэж байгууллагын пэйж хуудсаар түгээн 1400 хүнд хүргэсэн. | | | |
| | 80 | | 2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих | Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Эрдэнэс алт ресурс" ХХК, "Болор жонш" ХХК-ууд баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашигласан усаа 85 хувьтай цэвэршүүлэн, цэвэрлэсэн усныхаа 70% -ийг дахин ашиглаж байна. "Дундговь-Ус" ОНӨҮГазрын 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 400м3/хоног бохир усыг 90%-тай цэвэршүүлж байна. Цэвэршүүлсэн усыг ногоон байгууламж, тэжээлийн ургамлын усалгаанд ашиглахаар бэлтгэл ажлыг хангаан ажиллаж байна. | 100 | | |
| 39 | 81 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | Дундговь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх эко клубийн 4 дэх удаагийн чуулганыг "Өсвөрийн байгаль хамгаалагч" уриан дор 06 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд "Их газрын чулуунд Аймгийн ЗДТГ, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн ангитай хамтран нийт 9 сумын 11 сургуулийн эко клубийн 104 багш, сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Чуулганаар өртөөчилсөн байдлаар "Байгаль хамгаалагч юу хийдэг вэ, Хүрээлэн буй орчны асуудлууд, Анхны тусламж хэрхэн үзүүлэх, Зүг чигээ хэрхэн олох, Хог хаягдлын 3R зарчим, Зэрлэг амьтан ургамлаа танин мэдэх нь сэдвүүдээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Монгол-Экологи төвтэй хамтран экологийн боловсрол олгох, Эко клубийн гишүүдийн дунд "Open mic" тэмцээн, Од, сар дурандах Их газрын чулууны уулан дотор явган аяллын маршрутын дагуу аялал хийж, чийг баригчтай эко хувинтай мод тарих арга хэмжээнүүдийг тус тус зохион байгууллаа. Эх | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэлхийн цаг" Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эвент арга хэмжээ 03 дугаар сарын 23-ны өдөр "Ид шидийн орон"-д сурагч, багачууддаа зориулсан уур амьсгалын өөрчлөлтийг харуулсан баримтат кино үзүүлэх, "Дэлхийн усны өдөр"-ийн талаар мэдээлэл хүргэх, хог хаягдлаа ангилан ялгах дадлага сургалт хийх, "Open mic", хуучин хувцас дээр зураг зурах 5 арга хэмжээг зохион байгуулж, нэгдэх тухай уриалгыг крилл болон монгол бичгээр 117 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж, нийт 120 иргэн хамрагдсан. "Үнэт баялаг-Ус" рийлс бичлэгийн уралдаан зарлаж, амжилттай оролцсон 3 байгууллагыг шагнаж урамшууллаа.Усны өдрийг угтан Сайхан-Овоо, Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газар "Цэнхэр тууз" аян, "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан цэцэрлэг, сургуулийн 235 сурагчдад сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулав. | | | |
| 40 | 82 | Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01 | 3.4. Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; | Дундговь аймгийн Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад жимс жимсгэнэ, малын тэжээл, хүнсний ногоо тариалах талбайг энэ онд шинээр 15 га-д олгож тариалалтын ажлууд хийгдэж байна. | 100 | | |
| | 83 | | 3.8. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 84 | | 3.10. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах | ХХААГ | | | | |
| 41 | 85 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2022-11-25 Дугаар 2022_03 | 1.3 . Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэй болон хязгаарлагдмал/ зохион байгуулах тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх; | | | | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | | |
| 42 | 86 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314 | 2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ (2022-2032 он) төлөвлөгөөний хүрээнд тайлант хугацаанд тогтмол 4 арга хэмжээ, зохион байгуулж 9 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.Австралийн Элчин сайдын яам, Монголын номын сангийн холбоо ТББ-тай хамтран орон нутгийн номын сангийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хил хязгааргүй номын сан” төслийг Сайнцагаан сумын ЕБС-ийн номын санд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Ид шидийн орон Дундговь ХХХТ-тэй хамтран | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | зорилтод бүлгийн хүүхдүүдэд бүтээлчээр ном унших эрэг дадлагыг нэмэгдүүлэх, сэдэлжүүлэх зорилгоор "Амттай ном" бүтээлч уншлагын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.Орон нутгийн гэр урлаач нарын соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж 8 ханатай гэрийг хийлгэж, эдийн засгийн эргэлтэд оруулсан. Бүх нийтийн соёлын өвийн боловсролын хөтөлбөрт 1208 хүүхэд залуучуудыг хамруулж, үндэсний агуулга шингэсэн бүтээгдэхүүнээр 11400 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.<br>Гэр урлалыг дэмжих замаар гэрийн дагалдах хэрэгсэл болох эсгий дээвэр туурга, хялгасан хошлон бүслүүр, эргүүлэг, чагтага, бүрээс, монгол авдар, ширээ, сандал, эргэнэг, тулга, аргалын сав, галын хайч, яндан хийлгэж борлуулалт хийсэн. Мөн үйлдвэрлэгч өвлөн уламжлагч нарын бүтээлийг олон нийтэд сурталчлан захиалга авч өгч дэмжиж ажилласан.ТХДЖТ-н зүгээс ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч бяцхан хүүхдүүддээ зориулж "Эх дэлхийг ирээдүйдээ бүтэн үлдээе" уриан дор "Бүхнийг чадагч бяцхан туулай" хүүхдийн жүжгийг нийт 1600 хүүхдэд үзүүллээ. Монгол улсад анх удаа зохион байгуулагдаж буй холын зайн морин тойруулгын "HiPay Cup 2024" уралдааны нээлтэд ТХДЖТ-ын уран бүтээлчид амжилттай оролцсон. Нийт 6 арга хэмжээ зохион байгуулж 13947 иргэнд хүрч үйлчилсэн.<br>-"Бизнес хөгжлийн төв"-д хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулах нөхцөлийг бүрдүүлж, түрээсийн зардлыг 100 хувь, цахилгааны зардлыг 50 хувь орон нутгаас дэмжин ажилласнаар хөдөө орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэсэн барааг 10 хувийн шимтгэлтэйгээр бүтээгдэхүүнээ "Дундговьд үйлдвэрлэв" төвөөр дамжуулан борлууллаа. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | -Музейн боловсролын хөтөлбөрөөр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хүрээнд 200ш морин хуурын puzzle-ыг худалдан борлуулах, боловсролын хөтөлбөрт ашиглан нэвтрүүлж байна. Дундговь аймгийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлдэг “Тэмүүжин” студийн бүтээл даллагын сав, даахь үргээх ёс, домын хайч, хутгыг музейн боловсроын хөтөлбөрөөр дамжуулж, музейн дэргэдэх бэлэг дурсгалын дэлгүүрээр худалдан борлуулж брэнд бүтээгдэхүүн болгож, сурталчлан таниулж хамтран ажиллаж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарт чөлөөт уран бүтээлчид болон бүтээлийн санг төвлрүүлэн www.creativehub.mn вэб сайтад мэргэжлийн соёл, урлагийн байгууллага хоёр, соёлын төв нэгийг бүртгэж, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч дөрөв, уран бүтээлч дөрөв, музейгээс эрхлэн гаргасан 8 номыг тус тус бүртгэж ажилласан. Нийт 3 байгууллага, 16 иргэн бүтээл бүртгүүлж ажилласан. | | | |
| 43 | 87 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд Эрдэнэдалай сумын инженерийн дэд бүтцийн шугамын ашиглалт, хамгаалалтыг хувийн хэвшилд буюу “Үлэмж хурд” ХХК-д хариуцуулан одоогоор амжилттай ажиллаж байна. “Мандалын гэгээ” хот тохижуулах ОНӨААТҮГазрыг шинээр байгуулан аймгийн төвийн хог хаягдал, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, зам засвар, арчилгаа зэрэг төрийн зарим чиг үүргийн ажлыг хариуцуулан гүйцэтгүүлж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | | | | |
| 44 | 88 | Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402 | 1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | 2024 оны 6 сарын байдлаар тус аймгийн хэмжээнд цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хорооллын барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгож, ашиглалтад хүлээн аваагүй болно. | 100 | | |
| | 89 | | 1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд | 2024 оны 6 сарын байдлаар тус аймгийн хэмжээнд орон сууцны хорооллын барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэгийн зориулалтаар төлөвлөсөн ажлын зураг төсөл батлагдаагүй. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | | | | | |
| | 90 | | 2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн | Сайнцагаан сумын 7 дугаар багт байршилтай “Түмний хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд 150 ортой цэцэрлэгийн барилга төлөвлүүлэн загвар зургийг баталсан.<br>2. 2024 оны 6 сарын байдлаар аймгийн хэмжээнд "Түр цэцэрлэг" ажиллагаагүй болно. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | | | |
| | 91 | | 3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Шинээр батлуулан хүлээн авч буй сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд холбогдох норм дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг тусгуулж буй бөгөөд аймгийн төвийн Түмний хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд стандартын шаардлага хангасан 150 ортой цэцэрлэгийн барилга төлөвлүүлж байна. | 100 | | |
| 45 | 92 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг | 2024 оны орон нутгийн төсөвт Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих “Нээлттэй-Дундговь” хөтөлбөр хэрэгжүүлэхээр 200.0 сая төгрөг батлуулсан. Мөн ЭЗХЯ-нд Говийн бүсийн ХАА-н үйлдвэрлэлийн ТЭЗҮ, зураг төсөв-1,000.0 сая, “Бага газрын чулууны аялал жуулчлал”-ын бүсийн ТЭЗҮ, зураг төсөв-1,000.0 сая, Түмний хорооллын гадна шугам сүлжээний ажлын зураг, төсөл-150.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээ батлагдаж ажлын даалгавар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./ | | | | |
| | 93 | | 4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, | 2024 оны 6 сарын байдлаар Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Улаанбаатар хотоос 27 иргэн шилжиж ирснээс насанд хүрэгчид 19 иргэн, хүүхэд 8, өөр аймгаас нийт 5 иргэн насанд хүрэгчид 5, нийт 32 иргэн шилжин ирж суурьшсан байна. | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | | | | |
| 46 | 94 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй | 1.13. Аймгийн 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 7,531.9 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээ төлөвлөсөн. Дээрх төсөл, арга хэмжээнээс 21 ажлын гэрээ хийгдээд байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна. 1.14.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний мөнгөн хандивыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн дансанд байршуулж зарцуулалтыг ОНХС-ын журмаар төлөвлөн хэрэгжүүлж байна. 1.15. Тухайн зээлүүд хэвийн олгогдож байна. 1.16.Хугацаа болоогүй 1.17.АХБанкны орон нутгийн хотуудын НАА-г хөгжүүлэх 2 шатны төслийн гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан 3,001,650.2 төгрөгийг бүрэн төлж барагдуулсан | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| 47 | 95 | Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63 | 3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Энэхүү арга хэмжээгээр Баруун болон зүүн аймгуудын эрүүл бүсийн зарим сумдын үхэр сүргийн ээмэгжүүлж Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхээр заасан тул манай аймагт хамааралгүй заалт<br>Цаашид энэхүү заалтын хасуулах саналтай байна. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 96 | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 | 7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний газар болон хувийн хэвшлүүдтэй хамтран “Цахимд хэвшье” уриатай “Digital first D-1” үндэсний нээлттэй форумыг зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, аж ахуйн нэгжийг цахим шилжилтийг хийх арга зүйн зөвлөмж, аймгийн удирдах албан хаагчдад цахим шилжилтийг хийх бодлогын зөвлөмж зэрэг сургалтуудыг зохион байгуулж цахим технологийн үзэсгэлэн худалдаа, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулж уг арга хэмжээнд давхардсан тоогоор 800 иргэд, аж ахуйн нэгжүүд хамрагдлаа. Уг арга хэмжээний үеэр 300 гаруй иргэдэд цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулсан. 13 сумдын иргэд болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 23 агентлагуудын мэдээллийн ажилтангуудад цахим орчин дахь хүүхэд хамгааллын сургалтыг зохион байгуулсан. Нийт 15 удаагийн сургалтад 2500 орчим хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан. | 100 | | |
| 49 | 97 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119 | 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | МУ-ын Засгийн газрын 2024.03.06 №95 тогтоолын дагуу 26 нас хүрсэн цэргийн албыг ямар нэгэн хэлбэрээр хаагаагүй Дундговь аймгийн залуучуудыг мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч байна. хагас жилийн байдлаар цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан 6 иргэн хаасан. | 100 | | |
| 50 | 98 | Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга | 2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур | Дундговь аймагт Арина электроникс, Сайн электроникс ХХК-ууд салбараа нээж үйл ажиллагаагаа эхэлсэн. УБ хотоос шилжин ирсэн “Дэлгэрэх плас инженеринг” ХХК ахуй үйлчилгээний | 80 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120 | үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт; | төв нээхээр ЖДҮХС-н зээлд хамрагдахаар төслөө өгч шалгаруулалтын шатандаа явж байна. | | | |
| | 99 | | 3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай. | | | | |
| 51 | 100 | Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим | 1.3. “Тахь Ресурс” ХХК-ийн өмч, хөрөнгөд халдсан асуудлыг хуулийн дагуу шалгаж, дүнг танилцуулахыг | Аймгийн цагдаагийн газраас 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныар хэрэг бүртгэлтийн 232200002 дугаартай | 100 | Хэрэгжилт хангагдсан тул | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160 | Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт; | хэрэг нээн шалгалтын ажиллагаа явуулан шалгаж 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорын 141 дугаартай тогтоолоор хэрэг бүртгэлийн хэргийг хааж шийдвэрлэсэн. | | хяналтаас хасах | |
| | 101 | | 2. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт “Тахь Ресурс” ХХК-ийн өмч, хөрөнгөд халдсан асуудлыг шалгасан талаарх танилцуулгыг хүргүүлсэн. | 100 | Хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах | |
| 52 | 102 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241 | 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Төрийн албаны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан тооцоолол судалгааг гаргаж, аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 27-ын өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн 2023 оны төсөв тодотгож батлах тухай 25 дугаар тогтоолоор батлуулсан. Аймгийн засаг даргын 2023.01.16-ны өдрийн А/18 тоот захирамжаар үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс санхүүждэг төсвийн байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг 5 хувиар нэмэгдүүлэн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төсөвтөө багтаан олгосон. | 100 | Хүчингүй болсон тогтоол хэрэгжилтийг хасуулах саналтай | |
| 53 | 103 | Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар | 3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын | Нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төсөл хөтөлбөрийн хүрээнд 3-р ээлжид ашиглалтад орох 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай 7 цэцэрлэг, 8 сургууль, 7 дотуур байр нийт 22 | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266 | сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай | объектоос 7 цэцэрлэг, 8 сургууль, 6 дотуур байр нийт 21 объектын ариун цэврийн байгууламж ашиглалтад орж 95 хувийн гүйцэтгэлтэй байна. Говь-Угтаал сумын сургуулийн дотуур байр шинэ барилгын хамт ариун цэврийн байгууламж ашиглалтад орох бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар ариун цэврийн байгууламжууд ашиглалттай холбоотой цахилгааны зардал их өндөр гарч төсвөөс хэтэрсэн дүнтэй байна.Үүнд Дэрэн сумын сургууль 1.482.221 төгрөг, Дэрэн сумын цэцэрлэг 1.049.465 төгрөг, Цагаандэлгэр сумын сургууль 1.300.000 төгрөг, Эрдэнэдалай сумын сургууль 4.776.000 төгрөг Дэлгэрхангай сумын сургууль 1.850.000 төгрөг, Өндөршил сумын сургууль 1.480.000 төгрөг, Дэлгэрхангай сумын цэцэрлэг 600.000 төгрөгийн цахилгааны өр, Хулд сумын сургууль 500.000 төгрөг, Дэлгэрхангай сумын цэцэрлэг 1.026.800 төгрөгийн цэвэр бохир усны өр нийт 15.914.486 төгрөгийн ус, цахилгааны өр үүсээд байна. Хагас жил үүссэн өрийг нэгж байгууллагууд сар бүр төрийн сангийн мэдээнд тусган хүргүүлж байгаа бөгөөд Дэрэн сумын сургууль цэцэрлэг сумын ИТ-ийн хуралд оруулан шийдүүлээд байна. Эхний 6 сарын байдлаар нийт цахилгааны өр 14.387.686 төгрөг, цэвэр бохир усны өр 1.526.800 төгрөг байна.Цаашид төсөвтөө багтаан шийдвэрлэн ажиллаж, мөн орон нутгийн ИТХ, Засаг даргаар шийдвэрлүүлэхээр судалгааг гарган ажиллаж байна. | | | |
| 54 | 104 | Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278 | 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. | | | | |
| 55 | 105 | Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279 | 2..2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Махны худалдаа эрхлэгч иргэн ААНэгжүүд нь аймгийн төвийн суурин хүн амын хэрэгцээнд нийлүүлэхээр хувийн зардлаар нийт 293тн махыг /үхэр-10тн, хонь-258тн, ямаа-25тн/ нөөцөлсөн. 3 сараас эхлэн зах зээлд нийлүүлж эхэлсэн ба эхний хагас жилийн байдлаар худалдаанд байгаа нөөцийн үлдэгдэлийн мэдээгээр нийт 99,4 тн мах байгаагаас үхэр 5,0тн, хонь 55,7тн, ямаа 38,7тн байна. | Энэ бичигдсэн зассан уу | | |
| 56 | 106 | Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | 3. 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай. | Хагас жилийн байдлаар аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргаагүй болно. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-08-16 Дугаар 2023_294 | | | | | |
| 57 | 107 | Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304 | 2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | МУ-ын Засгийн газрын 2024.03.06 №95 тогтоолын дагуу 26 нас хүрсэн цэргийн албыг ямар нэгэн хэлбэрээр хаагаагүй Дундговь аймгийн залуучуудыг мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч байна. Хагас жилийн байдлаар цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан 6 иргэн хаасан. | 100 | | |
| 58 | 108 | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312 | 4. Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, цаашид жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай | Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2024 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, төсвийн төсөлдөө тусган хэрэгжүүлэн ажилласан. | 100 | | |
| | 109 | | Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол, 2023 оны 312 дугаар тогтоол аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/663 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны газар 6 албан хаагчийн орон тоотой байгуулагдсан. Орон нутгийн өмчийн газраас цалингийн сан, эд хөрөнгийн хамт зохих журмын дагуу шилжүүлсэн. | 100 | Хасах саналтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | 110 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгаанд улсын төсвийн 11,0 сая төгрөг, Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын үзлэгийг эрчимжүүлэх улсын төсвийн (ЭМДС) 186,8 сая төгрөг, Зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, болон халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт улсын төсвийн 71,6 сая төгрөг, Халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх товлолд болон нэмэлт дархлаажуулалтад улсын төсвийн 199,2 сая, орон нутгийн төсвийн 52 сая төгрөг, Сумдын эрүүл мэндийн төвийг мобайл технологиор хангах улсын төсвийн 15,2 сая төгрөг, ДЭМБ 76,8 сая төгрөг зэрэг хүн амын мэндийг дэмжих хамгаалахад зориулан зарцуулсан. | 100 | | |
| 60 | 111 | “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322 | 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, | Хагас жилийн байдлаар ерөнхий боловсролын 19 сургуулийн суралцагчдад “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд амны хөндийн бүтэц, эрүүл ахуй, угаах арга техникийн талаарх сургалтыг нийт 8848 суралцагчдаас 4123 суралцагч буюу 46 хувь нь суралцагч сургалтад хамрагдсан байна. 8848 суралцагч шүдний үзлэгт харагдсанаас 4967 суралцагч буюу 56 хувь нь хамрагдаж үүнээс 440 суралцагч буюу 0.08 хувь нь эрүүлжүүлэх үйлчилгээнд хамрагдсан байна.<br>Ерөнхий боловсролын 18 сургуулийн 6 сургууль буюу 33 хувь нь бага ангийн 835 суралцагчдыг сургуулийн орчинд 1-6 сарын хугацаанд шүдээ угааж байна. Мөн 2 ээлжээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг 4 сургууль ариун цэврийн орчны угаалтуурын хүрэлцээнээс шалтгаалан 1247 суралцагч содын уусмалаар амны хөндийг зайлуулж байна. Сургуулийн орчинд бага ангийн нийт 4457 сурагчдаас 2082 буюу 47 хувь нь шүдээ угааж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | 22 цэцэрлэгийн 2561 хүүхэд 100 хувь үдийн хоолны дараагаар шүдээ тогтмол угааж байна. Аймгийн хэмжээнд 5 цэцэрлэгийн 19 бүлэг ариун цэврийн өрөөнд сойз ариутгагчийг байршуулсан байсан бол 5 сарын байдлаар Адаацаг сумын дунд бүлэг ариун цэврийн өрөөндөө сойз ариутгагчийг байрлуулж нийт 22 цэцэрлэгийн 6 буюу 27 хувь нь сойзны эрүүл ахуй, халдвар хамгааллыг сайжруулаад байна. | | | |
| 61 | 112 | Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344 | 2.. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Сайнцагаан сумын иргэн ААНэгжүүд өөрсдийн хөрөнгөөр хавар, зуны улиралд аймгийн төвийн суурин хүн амын хэрэгцээнд нийлүүлэхээр нийт 293тн махыг /үхэр-10тн, хонь-258тн, ямаа-25тн/ нөөцөлсөн. 3 сараас эхлэн зах зээлд нийлүүлж эхэлсэн ба эхний хагас жилийн байдлаар худалдаанд байгаа нөөцийн үлдэгдлийн мэдээгээр нийт 99,4 тн мах байгаагаас үхэр 5,0тн, хонь 55,7тн, ямаа 38,7тн байна. 2025 оны Стратегийн хүнсний улирлын нөөц буюу 2025 оны хавар зуны улирлын суурин хүн амын хэрэгцээт махны нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг тусгуулахаар тооцооллыг хийж холбогдох газарт хүргүүлсэн. | 100 | | |
| 62 | 113 | Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449 | 3.3. Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, | Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар улсын нөөцийн бараа материалыг бүрдүүлж монгол улсын Засгийн газрын 2023-2024 оны 449, 479, 63 дугаар тогтоолоор худалдан борлуулж, аймгийн Засаг даргын 742, 18, 90 дугаар захирамжийн дагуу хуваарилан олгож, улиралд 1, хагас жилийн байдлаар 2 удаа сэлгэн байршуулж хэрэгжилтийг 100 хувь хангуулсан. ОБЕГ-аас “ЧТМО” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хивэг тэжээл, ОБЕГ-ын харьяа 185 дугаар ангиас эрдэст тэжээлийг хүлээн авч нуруулдаж хураасан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | | | | |
| 63 | 114 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456 | 1.1.. 1 .Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 1.1. .Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явЦ байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх; | Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцад хөрөнгийн зохицуулалт хийх шаардлага гараагүй. | 100 | | |
| | 115 | | 1.2.. 1.2. улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа | Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж /Дундговь, Хулд сум/, Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/ төсөл арга хэмжээний нийт 220.2 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлж 70,2 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг Сангийн яамаар нээлгэж санхүүжилт олгосон. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгийн дансанд байршуулах; | | | | |
| | 116 | | 1.3.. 1.3. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх. | Дээрх 2 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор барьцаа данснаас санхүүжүүлэхээр чиглэл өгөөд байна. Барьцаа дансанд байршуулсан санхүүжилтээс 70.2 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн Сангийн яамны зөвшөөрлөөр санхүүжүүлээд байна. | 100 | | |
| 64 | 117 | Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457 | 2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Дундговь аймгийн хэмжээнд 2024 онд орон нутгийн хөгжлийн санд нийт 15,244.5 сая төгрөгийн санхүүжилт хувиарлагдсанаас 15 сумдад зохих журмын дагуу 10.2 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлгийг хуваарилаад байна. | 100 | | |
| 65 | 118 | Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458 | 2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга | Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөнд Сайхан-Овоо суманд Онгийн голын “Мөсний баяр” арга хэмжээг 1 дүгээр сарын 18-нд болж 3 төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулж, 126 хүн оролцсон. | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах | | | | |
| 66 | 119 | Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461 | 4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай | ХХААГ | | | |
| 67 | 120 | 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481 | 4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай. | 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн тоотын дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.ЭЗХЯ-нд Говийн бүсийн ХАА-н үйлдвэрлэлийн ТЭЗҮ, зураг төсөв- 1,000.0 сая, “Бага газрын чулууны аялал жуулчлал”-ын бүсийн ТЭЗҮ, зураг төсөв-1,000.0 сая батлагдаж ажлын даалгавар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэв. | 70 | | |
| 68 | 121 | Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга | 2.8.. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг | Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ашиглалтын шаардлага хангахгүй болсон талаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу Сайнцагаан сумын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483 | бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт; | 7-р багийн 1,2-р байрны оршин суугчид тус 2 барилгыг буулгаж дахин төлөвлөх хүсэлт гаргасан. Тус хүсэлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тус 2 барилгыг буулгаж 0.3 га газрыг дахин төлөвлөлтөд оруулахыг дэмжсэн тогтоол гарч дахин төлөвлөлтийн төсөл боловсруулагдаж байна. | | | |
| | 122 | | 2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд; | 2024 онд Өндөршил сум ОНХС-ийн хөрөнгөөр 4 айлын сууц барихаар 429.2 сая, Гурвансайхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 12 айлын орон сууц барихаар 900.0 сая төгрөг батлан зураг төсөв боловсруулж байна. Эрдэнэдалай суманд хувийн хэвшлийн хөрөнгөөр 12 айлын орон сууц барихаар төлөвлөн зураг төсвийн ажил хийгдэж байна. Орон нутгийн 650 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын 7 дугаар баг Мандал хорооллын гадна халаалтын зуухны дуусгалын ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажил ашиглалтад орсноор нийтийн болон хувийн орон сууц, аж ахуйн нэгжүүд халаалтад холбогдох нөхцөл бүрдэнэ. Тус ажлыг 2024 оны 7 дугаар сард ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. | | | |
| | 123 | | 2.10. Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай | Аймгийн 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дэрэн, Хулд сумдын төрийн албан хаагчийн их засварт нийт 821.0 сая төгрөг баталж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Ингэснээр тус сумдад ажиллаж, амьдарч байгаа | 90 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд; | эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. 2024 оны аймгийн ОНХС болон ОНХО-аар тус хорооллын гадна бохир усны шугамын ажилд 208.9 сая, гадна цахилгаан хангамж, дэд станц байгуулах ажилд 89.0 сая нийт 297.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Сайнцагаан сумын айраг баг, Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 0.4кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих ажилд нийт 498.6 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталснаар ойролцоогоор 1000 гаруй өрхүүд өмчилж авсан газартаа амьдрах орчин бүрдэж байна. Аймгийн 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дэрэн, Хулд сумдын төрийн албан хаагчийн их завсарт нийт 821.0 сая төгрөг баталж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Ингэснээр тус сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн. | | | |
| 69 | 124 | Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41 | 3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Жил бүрийн 8 дугаар сард зохион байгуулагдахаар товлогдсон. | ХБ | | |
| 70 | 125 | Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, | 6.. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, | Эхний хагас жилийн байдлаар 3 томоохон арга хэмжээг зохион байгуулж "GO MONGOLIA" аяны хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэнд орон нутгийн онцлогийг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59 | аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. (5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.) | шингээсэн 8 ханатай халх гэрт Морин хуур хөгжмийг залж, гадаад дотоодын жуулчдад таниулан сурталчилсан. Нийт 11400 иргэдэд мэдээлэл өгсөн. Морин хуурыг түгээн дэлгэрүүлэх, үр хойчдоо өвлүүлэн уламжлуулж, дэлхий дахинаа сурталчлан таниулах үүднээс холбогдох яамдтай хамтран ЕБС-ын боловсролын хөтөлбөрт морин хуурын сургалтыг нэвтрүүлсэн. Сум бүрийн Соёлын төвийн дэргэдэх дугуйлан, урын сангийн судалгааг 14 сумын соёлын төвөөс авч нийт уртын дуугаар 281, морин хуураар суралцаж байгаа 183 суралцагч байна. Тус уртын дуу, морин хуурын дугуйлангуудыг тогтмолжуулах арга зүйн чиглэлийг сар бүр тогтмол өгч ажиллалаа. | | | |
| 71 | 126 | Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62 | 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. (1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын | Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб нь үйл ажиллагаагаа жигдрүүлэн явуулж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 23 удаа хуралдаж, 36 удаагийн албан үүрэг, албан бичгийг гарган сумдын Онцгой комисс, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж, Сумдын Онцгой комисс, Шуурхай штабыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, Улсын Онцгой комиссын Шуурхай штабыг мэдээ, мэдээллээр өдөр бүр хангаж ажилласан. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаж аймгийн Шуурхай штаб, сумдын шуурхай штабыг байгуулан үүрэг чиглэл өгч, Улсын Онцгой комиссын шуурхай штабыг мэдээ мэдээллээр цаг тухайд хангаж ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.) | | | | |
| | 127 | | 3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1. Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд | Аймгийн Онцгой комиссын 2024 оны 03 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын А/100 дугаар захирамжаар малчдад туслах “Хамтдаа давья” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд нийт 109.0 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал, 153.0 сая төгрөг цуглаж аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын даргын баталсан хуваарийн дагуу сумдад хуваарилан олгосон. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| | 128 | | 3.3.. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), аймгийн Засаг дарга нарт, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт; | Аймгийн Онцгой комиссын 2024 оны 03 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын А/100 дугаар захирамжаар малчдад туслах “Хамтдаа давья” аяныг зохион байгуулсан.Аяны хүрээнд нийт 109.0 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал, 153.0 сая төгрөг цуглаж аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын даргын баталсан хуваарийн дагуу сумдад хуваарилан олгосон. | 100 | | |
| | 129 | | 3.8.. Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт. | Дундговь аймгийн хэмжээнд нийт 15 сумын 281 малчин өрхийн гэр, хороо бууцанд цас ихээр хуримтлагдсан, шар усны үерт өртөх эрсдэлтэй байсныг аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн анги, сумдын Шуурхай штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг дайчлан тус айл өрхийн хороо бууцыг цаснаас гаргах ажлыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд аймгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн давхардсан тоогоор 225 хүн, 8 ковш, 84 автомашин, Онцгой байдлын газрын 18 алба хаагч, механизм /1 ковш/, | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2 автомашинтай, нийт 254 хүн, 97 техник хэрэгсэлтэй ажилласан. | | | |
| 72 | 130 | Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76 | 2 . Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | ХХААХҮС-ын 2024 оны "Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 101 дугаар тушаалаар олгосон 750 тн улаан буудай, хошуу будааг 15 суманд хуваарилж малчдад хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн ОХУ-аас тусламжаар олгосон 350тн улаан буудай, 100тн овьёосны үр олгосноос аймгийн Засаг даргын 2024 оны "Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг урьдчилан бэлтгэх тухай" А/330 захирамжийн дагуу тэжээлийн ургамал тариалуулахаар 15 суманд 50,5 тн овьёос, 17,5 тн улаан буудайн үрийг хуваарилан бүрэн олгосон. | 100 | | |
| 73 | 131 | Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77 | 3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”) | | | | |
| 74 | 132 | Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82 | 2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.) | 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс эхлэн хөдөөгийн сумд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 40 хувь, аймгийн төвийн төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 20 хувь, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн төрийн захиргааны албан хаагчдын ажлын идэвх санаачилга, үр дүнг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувиар орон нутгийн төсвөөс нэмэгдүүлэн олгохоор шийдвэрлэн орон нутгийн төсөвтөө тусган ажилласан. | 100 | | |
| 75 | 133 | Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83 | 3. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, | Мөнгөн урамшуулал олгоход 2024 оны төсөвт 101 албан хаагчдын 774,238,9 мянган төгрөгийг төсөвт суулган санхүүжүүлж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.) | | | | |
| 76 | 134 | Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай 2024-03-06 Дугаар 2024_89 | 2. Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан, холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Тусгай зориулалтаар 2024 онд агнах барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 89 дүгээр тогтоолоор 2024 онд Дундговь аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар угалз 2, тэх 4, цагаан зээр 20 тоо толгой агнуулах зөвшөөрөл батлагдаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2024 оны 03 дугаар сарын 26 өдрийн 01/1339 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 18-ний А/247 дугаар “Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай” захирамж гарган, нээлттэй дуудлага зарлан холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулан ажиллаж байна. | 70 | | |
| 77 | 135 | Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-04-03 Дугаар 2024_136 | 2.. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох | Уг тогтоолоор Дундговь аймгийн хэмжээнд нийт 368 нэгж талбарт 5938.19 га газрыг эзэмшүүлж, ашиглуулахаар батлагдсан бөгөөд тогтоолын дагуу хагас жилийн байдлаар 51 нэгж талбарын 415.26 га газрыг иргэн, аж ахуй нэгжид эзэмшүүлж, ашиглуулан газрын кадастрын цахим системд бүрэн оруулсан. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гараагүй болно. Уг тогтоолоор Дундговь аймгийн хэмжээнд нийт 368 нэгж талбарт 5938.19 га газрыг эзэмшүүлж, ашиглуулахаар батлагдсан бөгөөд тогтоолын дагуу хагас жилийн байдлаар 51 нэгж талбарын 415.26 га газрыг иргэн, аж ахуй нэгжид эзэмшүүлж, ашиглуулан газрын кадастрын цахим системд бүрэн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. (“Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Улсын тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт) | оруулсан.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гараагүй болно. | | | |
| 78 | 136 | Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162 | 3. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах төсөл арга хэмжээ батлаагүй тул гэрээ хийгдээгүй. | 30 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 79 | 137 | “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 2024-04-24 Дугаар 2024_166 | 3.. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсугэй. | Мал аж ахуйн салбарт үүссэн нөхцөл байдалтай холбоотой Шинэ хоршооны гишүүн малчин өрхөд 80-100 хувийн батлан даалттай жилийн 6 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай зээлийг Арилжааны банкны эх үүсвэрээр олгож байна. Засгийн газраас зээлийн хүйний зөрүү болох 12 хувийг арилжааны банканд төлнө. Уг төслийн хүрээнд 15 хоршооны 50 гишүүний 1,295,8 сая.төгрөгийн зээлийн хүсэлтийг хүргүүлсэн байна. Үүнээс 36 гишүүний батлан даалтын шийдвэр ирж гэрээ байгуулах шатандаа орсон байна. | 100 | | |
| 80 | 138 | Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 Дугаар 2024_168 | 1.. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай | | | | |
| 81 | 139 | Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай | 1.. Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга | 2023 оны жилийн эцсийн байдлаар тэмээ 43708, адуу 194643, үхэр 85520, хонь 1759946, ямаа 1577298 нийт 3661115 мал тоологдсоноос Тэмээ 612, адуу 30108, үхэр 5399, хонь 132732, ямаа 118224 нийт 287075 мал хорогдож нийт малын 7.84 хувийн хорогдолтой байна. Малын сэг зэмийг цуглуулж, булшилж устгах ажлыг зохион байгуулж тэмээ 341, адуу 33404, үхэр 8743, хонь 126313, ямаа | 100 | Хэрэгжилт нь хангагдсан тул хяналтаас хасах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024-04-24 Дугаар 2024_173 | хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай | 112318 нийт 281119 сэг зэмийг устгаж 97.9 хувьтай хийгдсэн байна. Малын сэг зэм устгах ажилд сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 45 малын эмч, мэргэжилтэн, Сумдын ЗДТГ-аас 171, орон нутгаас 374, цагийн ажилтан 205 нийт 795 хүн ажиллаж байна. Суудлын автомашин 40, ковш 27, экскаватор 17, Ачааны авто машин 216, нийт 300 техник хэрэгсэл ажилласан байна.<br>Түлш шатахуун 51484 литр дизель түлш, 10474 литр АИ-92 нийт 61958 литр шатахуун зарцуулаад байна. Техник хэрэгслийн түрээс, цагийн ажилтны хөлс, түлш шатахууны зардал нийт 405451160 төгрөгийн санхүүжилтийг сумдын өөрийн нөөц хөрөнгө болон зээлээр зарцуулаад байна. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 105600000 төгрөг сумдад хуваарилсан. | | | |
| | 140 | | 2.. Малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, иргэд, малчидтай орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан байгуулах гэрээт ажлын хөлсийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохих журмын дагуу гаргахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | Дундговь аймагт 366 иргэнийг сэг зэм устгах ажилд ажиллуулах квот ирсний дагуу сумдын малын хорогдлыг үнэлэн хуваарийн дагуу 14 сумын 298 иргэнийг ажиллуулж, ажлын хөлсөнд 119.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Х.Булгантуяад тус тус даалгасугай | | | | |
| 82 | 141 | Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187 | 4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай | 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сайнцагаан, Дэлгэрцогт, Хулд, Адаацаг, Баянжаргалан сумд тодотгол оруулан малчдын хоршоонд 20 байршилд 72 га газрыг төлөвлөн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. 15 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн Засгийн газрын 136, 137 дугаар тогтоолоор 2024 онд иргэн ААНБ-д эзэмшүүлж өмчлүүлж, эзэмшүүлэх газрын жагсаалт батлагдсан бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар Цахим системээр дамжуулан аймгийн хэмжээнд 49 байршилд 634,06 га газрыг иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлж өмчлүүлж ашиглуулсан байна. | 100 | | |
| 83 | 142 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай | 3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн | “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-д байгууллагын албан хаагчдын мэдээллийг үнэн зөв оруулах талаар Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлагт чиглэлийг хүргүүлсэн. | 20 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024-05-08 Дугаар 2024_196 | бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | | | | |
| 84 | 143 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2024-05-22 Дугаар 2024_228 | 2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн авто замын засварын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус даалгасугай | | | | |
| | 144 | | 3.. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус үүрэг болгосугай | | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 85 | 145 | 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19 | II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын | Барилгын ажил зогсоод буй "Төв халхын дуулалт жүжгийн театр"-ын ажлын зургийн өөрчлөлт, интерьер, тайз технологийн зургийн дуусгалын ажилд аймгаас 220.0 сая төгрөг батлан зураг төсөв магадлалаар батлуулах шатанд явж байна. 2024 онд УТХО-д “Цагаандэлгэр сумын халуус ус, үйлчилгээний төвийн барилга” ажлын төсөвт өртөг нэмэгдэж батлагдсантай холбогдуулан тус ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Одда тайж" ХХК-тай 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан БХБЯ/201802067 тоот гэрээнд заасан 237.3 сая | 30 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | төгрөг гэсэн үнийн дүнг 205.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж гэрээний нийт дүнг 443.0 сая төгрөг болгон баталж 2024 оны 09 сарын 30-ны өдөр барилгыг ашиглалтад оруулсан байхаар харилцан тохиролцож ажил эхлүүлээд байна. Ажлын гүйцэтгэл 30.0 хувьтай байна. | | | |
| 86 | 146 | 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14 | XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Цагаан сар, хүүхдийн баяр, хүнсний аюулгүй байдал сарын аяны хүрээнд Сайнцагаан, Өндөршил, Баянжаргалан сумдын хүнсний худалдааны 29 газарт хяналт шалгалт хийсэн. Худалдааны газруудад худалдаалагдаж буй хүнсний ногоо, жимс, тахианы махны гарал үүсэл, шинжилгээний бичиг баримтад хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар гарал үүслийн бичиггүй, шинжилгээний бичгийг бүрэн аваагүй дутагдлыг тухайн газар дээр нь арилгуулж, худалдааны лангуу тавиурт хатаж чийгээ алдсан, 4 төрлийн 2,3 кг хүнсний ногоог газар дээр нь устгуулж, бараа бүтээгдэхүүний бүртгэл хөтөлгөө, лангуу тавиур дутуу байсан 2 дутагдлыг тухайн газар дээр нь арилгуулж ажилласан.<br>Үр дүн: Муудсан хүнсний ногоо худалдаалагдахаас урьдчилан сэргийлсэн. Байгууллагын дотоод хяналтыг сайжруулахад зөвлөгөө зөвлөмж өгснөөр хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг тогтмол хөтөлдөг болсон байна. | 100 | | |
| 87 | 147 | 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24 | XIY.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг | 2018 онд тус аймгийн 15 сумын суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 15 сумын тэг гортигийг цахимжуулж оруулсан ба | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | суурьшлын бүс дотроо газар олголт явагдаж байгаа тул тэг гортигийг тэлэх шаардлагагүй болно. | | | |
| 88 | 148 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 21162 иргэн буюу 66 хувьд олгоод байна. 2024 оны хагас жилийн байдлаар нийт 1814 иргэнд олгосноос тоон гарын үсгийг 731 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1083 иргэнд гар утасны gsign апплекейшнаар, нийт 549 иргэн киоск машинаар авсан байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 89 | 149 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 | XҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Халдварт бус өвчлөлийн түвшин 10000 хүн амд Нийт 134 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 28,7 промилль болж өнгөрсөн оны мөн үеэс 147 тохиолдлоор буурсан байна. Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл БЗДХӨ- 30.6%, Амьсгалын замын халдвар 56,0% , Сүрьеэ-8,2%, бусад өвчлөл 5,2% байна. **Зарцуулсан төсөв УТХО 18,3** Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын үзлэгийн хамрагдалт эхний 5 дугаар сарын байдлаар:<br>• 0-5 нас 3815 (60,7%),<br>• 06-17 нас 8446 (81,7%),<br>• 18-аас дээш 8739 (28,6%) тус тус хамрагдаж хамрагдалтын хувь 44,5 болсон байна.<br>**Зарцуулсан санхүүжилт УТХО (ЭМДС) 186,6**<br>Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 22795 иргэнээс 5844 буюу 25,6%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 15652 иргэнээс 5866 буюу 37,5%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2295 иргэн хамрагдахаас 852 буюу 37,1%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8043 иргэн хамрагдахаас 2344 буюу 29,1%-тай хамрагдсан байна. Зорилтот иргэдийн үзлэгт хамрагдалт 32,3% байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 198, чихрийн шижинтэй 315 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авч эмчилгээ үйлчилгээ хийж байна. | 100 | **Зарцуулсан төсөв УТХО 71,6** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 90 | 150 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | X.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | 19 сургуулиас 15, 22 цэцэрлэгээс 19 цэцэрлэг нийт 34 байгууллага эзэмшлийн газраа Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоолоор дахин үнэлүүлсэн. 4 сургууль, 3 цэцэрлэг эзэмшлийн газартаа 2018 оноос хойш шинээр захирамж гаргуулж гэрээ байгуулан үнэлүүлсэн. 19 сургуулийн 586967.8 м2 газрыг 2094555600 төгрөгөөр, 22 цэцэрлэгийн 123969.5 м2 газрыг, 455769000 төгрөгөөр тус тус үнэлж бүртгэлд тусгасан байна. | 100 | | |
| 91 | 151 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар | Цахим шилжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд болон сумдын Засаг даргын Тамгын газруудын 100 хувь албан бичиг солилцооны дундын систем DOCX-д холбогдож, бүх төрийн байгууллагуудад албан бичгээ цахимаар илгээж байна. Сумдын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд албан бичиг солилцооны дундын системд холбогдож, хоорондын албан бичиг солилцоо 100 хувь цахимаар явагдаж байна. "Цахим сум, байгууллага" аяны удирдамжийг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | сум, байгууллагуудад хүргүүлсэн. Мөн Цахим сум, байгууллага аяны хүрээнд төлөвлөгөө гаргаж ажиллах талаар аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | |
| 92 | 152 | 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4 | VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | 3 байгууллагын 14 автомашиныг татан төвлөрүүлснээс 1 буюу Адаацаг сумын ЗДТГ-ын автомашин худалдан борлуулагдаагүй үлдсэн. Аймгийн ИТХ-ын 2023 оны 19 дүгээр тогтоолын дагуу Адаацаг сумын ЗДТГ-ын 20-66 ДУЭ улсын дугаартай Nissan murino маркийн автомашинд 2023 онд 3 удаагийн дуудлагын худалдааг зарласан боловч амжилтгүй болсон. Иймд “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах” журмын 2.2 дахь заалтын дагуу үнийг 50% бууруулан аймгийн ИТХ-ын 2023 оны 73 дугаар тогтоолын дагуу 2024 онд 3 удаагийн дуудлагын худалдааг зохион байгууллаа. Гэвч тус дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй учраас амжилтгүй болж, одоогийн байдлаар тухайн тээврийн хэрэгслийг акталж, сэлбэг хэрэгслээр ашиглах хүсэлтийг тухайн байгууллага албан бичгээр ирүүлсэн. | 90 | | |
| 93 | 153 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 | XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, | Ус цаг уурын байгууллагын мэргэжилтнүүдийн баг, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын захиалгаар ТББ-аар гүйцэтгүүлсэн болон аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газраас хийсэн нийт 12 судалгааны ажлыг тус мэдээллийн санд байршуулж 5452 иргэн нээж үзсэн нь өмнөх сараас 10,5 хувь, 2712 иргэн судалгааны ажлуудыг татан | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | авсан нь өмнөх сараас 14,2 хувиар тус тус хандалтын тоо өссөн үзүүлэлттэй байна. Одоогоор судалгааны ажлуудад санал сэтгэгдэл үлдээсэн мэдээлэл байхгүй байна. | | | |
| 94 | 154 | 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10 | XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | 2024 оны хагас жилийн байдлаар гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний тохиолдол бүртгэгдээгүй. | 100 | Хэрэгжилт нь хангагдсан тул хяналтаас хасах | |
| 95 | 155 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендерийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын | Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг 5 зорилго, 30 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендерт суурилсан хүчирхийлл болон охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нэг тэрбумаараа тэмцье” эмэгтэйчүүдийн эрх чөлөөний алхалт, “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоохын төлөө Дэлхийн өдөр” нөлөөллийн арга хэмжээнд тус тус зохион | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жендерийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендерийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав | байгууллаа. Аян арга хэмжээнд 533 хүүхэд, эцэг эхчүүд, албан хаагчид хамрагдсан байна.Олон улсын гэр бүлийн өдрөөр “Хайр дүүрэн гэр бүл” өдөрлөгийн хүрээнд “ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ҮР БҮТЭЭМЖТЭЙ ЦАГ” сэдэвт сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Уг сургалтын үйл ажиллагаанд 34 байгууллагын 250 гаруй төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа. Гэр бүлийн харилцаа, гэр бүл дэх таны байр суурь, цахим гэмт хэрэг, 108 утасны талаар мэдээлэл агуулсан 650 ширхэг брошюр тарааж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19.1.8-д заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендерийн үндэсний хороонд хүргүүлнэ. | | | |
| | 156 | | XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн | Эхний хагас жилийн байдлаар 0-5 насны хүүхдийн 60.7%, 6-17 насны 81.7%, 18-аас дээш насны 28.6%-ийг хамруулаад байна.Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 3031 хүүхэд буюу нийт хүүхдийн 27.6%-ийг хамруулж, 367 буюу 12.1% шүдний өвчлөлтэй байлаа. Илэрсэн өвчлөлийн эрүүлжилт 38.1% байна. Амны хөндийн эрүүл ахуй урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 5840 хүүхдэд 4 төрлийн сургалт, цахим хуудсаар 102 төрлийн постер, контент, хөдөлгөөнт зураг зэргээр мэдээлэл оруулсныг 11670 хүн үзэж мэдээлэл авсан байна. Аймгийн хэмжээнд ходоодны уян дуранг 2023 оны улсын төсвийн 272,8 сая төгрөгөөр олгосон ба хэвийн ажиллаж байна. Нийт 11508 хүнд үзлэг, оношилгоо хийсэн байна. Үүнээс ходоод, улаан хоолойн үрэвсэл, шархлаа 3494, ходоодны өмөн 51, улаан хоолойн өмөн 20, улаан хоолойн вений өргөсөл 3, хавдрын хяналтад 2, эрүүл ходоод 5, улаан хоолойн хавдрын урьдал 2, архаг цус алдагдал хавсарсан 1, | 100 | **Зарцуулсан төсөв УТХО 2,3**. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | бусад ходоодны архаг үрэвсэл, ходоодны хатангиршил бүртгэгдсэн байна. | | | |
| 96 | 157 | 2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13 | IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод | Тус аймгийн Дэрэн, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Сайхан-Овоо сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй ба дээрх сумдад 2024 онд газар олголт хийгдэхгүй. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан байршилд газрыг эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлж байна. Төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд газар олгох шийдвэр гараагүй болно. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | | | | |
| 97 | 158 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмж 2024 оны эхний хагас жилийн байдлаар ирээгүй байна. | 100 | | |
| 98 | 159 | 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18 | XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг аймгийн өдөр бүр тогтмол ард, иргэдэд хүргэж “Дундговийн амьдрал” сонин болон бүх төрлийн мэдээллийн сувгаар давхардсан тоогоор 53342 иргэнд мэдээллийг хүргэж, 17213 хүнд гарын авлага, санамж хүргэж ажилласан. | 100 | | |
| 99 | 160 | 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21 | XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | | | | |
| 100 | 161 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; | Дундговь аймаг /shilen.gov.mn/ мэдээллийн нэгдсэн системд бүх сум, байгууллагын эрхийг үүсгэн бэлэн байдлыг хангасан бөгөөд аймгийн хэмжээнд 6 сум, 10 байгууллага нээлттэй мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангаг өөрийн цахим хуудас болон нэгдсэн систем /shilen.gov.mn/ - д мэдээллээ байршуулж үнэлгээ баталгаажсан байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах. | | | | |
| 101 | 162 | 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25 | XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, | Засаглалын менежмент-нутгийн хөгжил” удирдах албан хаагчдын сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөний үед “Алсын хараа-2050” болон “Шинэ сэргэлтийн бодлого”, бүсчилсэн хөгжлийн бодлого хоорондын уялдаа, зорилго зорилтыг төрийн албан хаагчдад танилцуулах илтгэл тавилаа. Тус зөвлөгөөнд Агентлаг, сумдын удирдах албан тушаалтнууд (Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, сумдын Засаг дарга, агентлагийн дарга, Төсвийн шууд захирагч нар, сумдын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн алба, сумдын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл) нийт 300 хүн хамрагдав. "Төрийн бүтээмжийн сэргэлт - Цахим эрүүл мэнд" сэдэвт сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Дундговь аймагт зохион байгуулж бүх шатны эрүүл мэндийн салбарт ажиллаж буй удирдах ажилтан, эмч, мэргэжилтэн нийт 270 хүн хамрууллаа. Тус сургалтын үеэр | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Алсын хараа-2050” болон “Шинэ сэргэлтийн бодлого”, бүсчилсэн хөгжлийн бодлого хоорондын уялдаа, зорилго зорилтыг төрийн албан хаагчдад танилцуулга хийсэн. | | | |
| | 163 | | XIII.5.3. Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын манлайллаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, хурлуудаас гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэн шалгаруулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Дээрх зөвлөгөөнд оролцогчдоос санал, хүсэлт, өргөдөл, гомдол, шинэлэг санал санаачилгыг зөвлөгөөний аль ч үед хүлээн авах боломжтой QR байршуулсан бөгөөд гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэсэн. | 100 | | |
| | 164 | | XIII.10.. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж | Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний газар болон хувийн хэвшлүүдтэй хамтран “Цахимд хэвшье” уриатай “Digital first D-1” үндэсний нээлттэй форумыг зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, аж ахуйн нэгжийг цахим шилжилтийг хийх арга зүйн зөвлөмж, аймгийн удирдах албан хаагчдад цахим шилжилтийг хийх бодлогын зөвлөмж зэрэг сургалтуудыг зохион байгуулж цахим технологийн үзэсгэлэн худалдаа, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулж уг арга хэмжээнд давхардсан тоогоор 800 иргэд, аж ахуйн нэгжүүд хамрагдлаа. Уг арга хэмжээний үеэр 300 гаруй иргэдэд цахим орчин дахь хүүхэд хамгааллын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав. | чиглэлээр сургалт зохион байгуулсан. 13 сумдын иргэд болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 23 агентлагуудын мэдээллийн ажилтнуудад цахим орчин дахь хүүхэд хамгааллын сургалтыг зохион байгуулсан. Нийт 15 удаагийн сургалтад 2500 орчим хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан. | | | |
| 102 | 165 | 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39 | XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт; | 2024 онд дуусах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн он дамжин хэрэгжих 14 төсөл арга хэмжээнээс энэ онд дуусах 9 төсөл арга хэмжээ байна. Дээрх ажлуудыг 7 төсөл арга хэмжээний гэрээ байгуулан ажил хийгдэж эхлээд байна. | 100 | | |
| | 166 | | XVIII.1.2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт | Дундговь аймаг дах Төрийн аудитын газраас Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын зөвлөмжөөр “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил”-ын барилгын ажил гүйцэтгэгч “Өлзийхутагийн наран” ХХК хууль хяналтын байгууллагад шилжүүлж, ажлыг бүрэн дуусгуулах арга хэмжээ авч ажиллах" гэж заасны дагуу хуулийн байгууллагад шилжүүлэхээр ХЭЗХ-тай хамтран материал бэлтгэж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 167 | | XVIII.1.4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт | “Өлзийхутагийн наран” ХХК хууль хяналтын байгууллагад шилжүүлж, ажлыг бүрэн дуусгуулах арга хэмжээ авч ажиллах" гэж заасны дагуу хуулийн байгууллагад шилжүүлэхээр ХЭЗХ-тай хамтран материалыг бэлтгэж байна. | 70 | | |
| | 168 | | XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Зураг төсөл батлагдсан газар эзэмших,ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц шийдэгдсэн барилга,байгууламжийн төслийг 2025 оны улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл,арга хэмжээний саналд тусгахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 | | |
| 103 | 169 | 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл | 2.6. Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн | Өмнөх онд Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авснаар тус хорооллыг дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж эхлээд байна. Хаус хороолол төлөвлөсөн нийт 8 га талбайд цэвэр | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-10-04 Дугаар 2023_40 | ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт; | бохир, ус, халаалтад холбогдсон, хашаа, гарааштай орчин үеийн шийдэл бүхий 119 амины орон сууц байх юм. 2024 оны аймгийн ОНХС болон ОНХО-аар тус хорооллын гадна бохир усны шугамын ажилд 208.9 сая, гадна цахилгаан хангамж, дэд станц байгуулах ажилд 89.0 сая нийт 297.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Мөн Сайнцагаан сумын айраг баг, Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 0.4кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих ажилд нийт 498.6 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталснаар ойролцоогоор 1000 гаруй өрхүүд өмчилж авсан газартаа амьдрах орчин бүрдэж байна.2024 оны аймгийн хөрөнгө оруулалтаар Дэрэн болон Хулд сумын төрийн албан хаагчдын байрны засварт 821.1 сая төгрөгийг батлаад байна. | | | |
| | 170 | | 2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засагдарга нарт; | Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил , үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэхээр цахим хуудсанд санал асуулга авч дүнг нэгтгэн батлуулахаар ИТХ-д албан тоот хүргүүлсэн. | Засагдах эсэх | | |
| | 171 | | 2.28. Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв | Сангийн яамны Төсвийн бодлого , төлөвлөлтийн газраас авсан санал маягтын дагуу судалгааг гарган баяр наадмын зардлыг нэмэх саналаа хүргүүлсэн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагад танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| | 172 | | 2.49. Дундговь аймгийн нутагт дэвсгэрт идлэг шонхор шувуу барих, гадаад улсад гаргах квотыг цуцлах хүсэлтийг судлан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт; | Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоолоор баталсан 2023 онд соёлын зориулалтаар гадаад улсад гаргах идлэг шонхор шувууны тоо хэмжээг батальсны дагуу аймгийн Засаг дарга гадаадын 13 иргэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2023 оны 8 дугаар сарын 14-өөс 2023 оны 11 дүгээр сарын 15-ны хооронд шонхор барих үйл ажиллагаа явагдсан бөгөөд гэрээний дагуу шонхор барих үйл ажиллагааг Адаацаг, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн сумдад зохион байгуулагдаж 9 шонхрын акт үйлдэгдэж холбогдох төлбөр хураамж сумын дансанд шилжигдэн орж 2023 оны шонхор шувуу барих гэрээ дуусгавар болсон. Эрдэнэдалай суманд гадаадын иргэн болон нутгийн иргэдийн хоорондын үл ойлголцлоос шалтгаалж тус суманд баригдсан 2 шонхор шувууг тавьж, акт үйлдэлгүй, шонхор шувуу барих үйл ажиллагааг зогсоосон. 2024 онд шонхор барих гэрээ байгуулах арга хэмжээ хийгдэж эхлээгүй. | 100 | 2024 оны шонхор барих гэрээ байгуулах арга хэмжээ хийгдэж эхлээгүй. Хасуулах саналтай байна | |
| | 173 | | 2.51. Дундговь аймгийн Сайнцагаан суманд болсон үерийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг эрчимжүүлэх, хохирсон иргэдэд шаардлагатай туслалцаа үзүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбатад; | Үерийн усанд автсан 210 гаруй айлын эд хогшлыг зөөж, нүүлгэн шилжүүлсэн. 35 орон сууцны зоорины давхар, авто зам усанд автсаныг 55 хүн, 11 машин, 8 мотопомп ажиллаж 6500 м3 усыг соруулсан. 121 айл өрхийн хашаа, нүхэн жорлон, 4 албан байгууллага, нийтийн эзэмшлийн 3500 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн. 6 авто замын ус зайлуулах шугамыг нээж, 2550м замын далан шуудууг засварласан. | 100 | ОНТ-7 сая | |
| | 174 | | 2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын | Үер ус, дуу цахилгаан, мөндөр, нөөлөг салхины аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулах видео-6, мэдээ 17 удаа нийтэлж, ААНэгж байгууллага, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ. | талбайд 200 ш сэрэмжлүүлэг нааж байршууллаа. 150 өрхөд шуудуу, далан ухсан, цахилгааны утасны бүрэн бүтэн байдлыг хангасан, нүхэн жорлонг ариутгал халдваргүйтгэл хийсэн эсэхэд хяналт тавьж, мэргэжлийн ангийн 66 иргэнийг 1 удаа, 270 гаруй иргэнийг 5 удаа урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан. | | | |
| 104 | 175 | 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41 | XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Нийтийн эдэлбэр газарт ил задгай зөвшөөрөлгүй асгасан хог болон төвлөрсөн хогийн цэгийг Эрдэнэдалай 3 га, Луус 4 га, Баянжаргалан 0,2 га, Говь-Угтаал 5 га, Дэрэн 1 га, Гурвансайхан 5 га нийт 6 сум 18.2 га талбайг шууж булшилсан. Үүнээс төвлөрсөн хогийн цэгийн талбайн Дэлгэрцогт суманд 0.3 га талбайг шууж булшилж талбайн хэмжээг 0.3 га-аар багасгаж 128.8 га-аас 128.5 га болж буурсан. БОАЖСайдын 02 дугаарт албан даалгаврын хүрээнд сумдад нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 627 га талбайг цэвэрлэж 536 тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлсэн. Нийтийн их цэвэрлэгээнд 372 хүн оролцсон. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж цэвэрлэгээнд 30 байгууллага, төвийн 5 багийн иргэд оролцлоо. | 90 | | |
| 105 | 176 | 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45 | XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав; | | | | |
| 106 | 177 | 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл 2023-11-29 Дугаар 2023_48 | XIX.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийн хүрээнд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх, хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй 81 шийдвэрийг зохих журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээг тус тус 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав | Аймгийн хэмжээнд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэр байхгүй ба дээрх асуудалтай холбоотой захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээгүй болно. | 100 | Хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | 178 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49 | XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов.” | Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/05 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж зудын гамшигтай тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэн, аймаг сумын шуурхай штабыг 24 цагаар, төрийн байгууллагын цагийн хуваарийг уртасгасан цагаар ажиллуулж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. | 100 | | | |
| | 179 | | XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | | | | | |
| 108 | 180 | 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51 | XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | Эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан иргэдийн судалгааг сум тус бүрээр гарган бүртгэлжүүлж, хамрагдаагүй иргэдийг дуудан хамруулах ажлыг зохион байгуулж байна. Эхний хагас жилийн байдлаар урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 47199 иргэн хамрагдахаас 20981 хамрагдаж, хамрагдалтын хувь 44.5 байна. Албан байгууллагуудад эрт илрүүлэх үзлэгт хамрагдаагүй албан хаагчдыг хамруулах талаар албан бичиг хүргүүлж, хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд 25 байгууллагын 400 албан хаагчийг хамруулаад байна. ЭМД-ийг төр хариуцдаг иргэдийн судалгааг гарган, хамрагдаагүй иргэдийг хамруулах ажлыг | 100 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулж байна. Мөн ЭМД-ийн хэлтсээс 18 удаагийн танхимын сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 400 гаруй хүнийг хамруулан даатгалын ач холбогдлыг сурталчлан ажиллаж байна. Улсын Нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтарсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог аймгийн хэмжээнд 6 суманд төвлөрүүлэн 15 хоногийн хугацаанд 18 дээш насны 1083 иргэнийг тус тус хамрууллаа. Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/26 дугаар тушаалаар нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй 5 ажлын хэсгийг томилгоожуулан хөдөөгийн 14 суманд урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог зохион байгуулж нийт 2052 хүнийг хамрууллаа. Үүнд: Хүүхэд 740, Дотор 549, эх барих, эмэгтэйчүүд 633, дүрс оношилгоо 130 нийт 2052 иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | | | |
| | 181 | | XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав | Булган аймгийн Чилэн, Говь-Сүмбэр аймгийн Малахын тал, Өвөрхангай аймгийн Хөх дэл Аймаг дундын отрын бүс нутгуудад 8 өрхийн 8984 толгой, хонин толгойд шилжүүлснээр 19297 тоо толгой мал өвөлжиж, хаваржуулахаар аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд хүсэлтийг хүргүүлж ажилласан. Өөрийн аймагт 155 өрхийн 89360 толгой мал, өөр аймгийн нутагт 98 өрхийн 51522 толгой мал, өөр аймгаас 116 өрийн 97039 тоо толгой мал ирж оторлосон нийт малчин өрхийн 3.4% нь отор нүүдэл хийсэн отор нүүдлийн талаар 100 хэрэгжсэн зөрчилдөөн гараагүй. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 182 | | XXV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг аргачлалын дагуу бодитой тогтоож шинэчлэн батлах тухай заалтыг Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах 2024 оны төлөвлөгөө, сумдын Засаг даргын Аймгийн Засаг даргатай байгуулах гэрээнд тусгаж батлуулж 2 сум шинэчлэн баталсан. Аймгийн ИТХ-аар Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардал, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг шинэчлэн батлуулахаар хэлэлцүүлж батлуулсан. Сайнцагаан, Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайхан-овоо, Эрдэнэдалай сумдад дахивар авах цэг ажиллаж байгаа бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 68 тонн дахивар нөөц цуглуулан дахин боловсруулах үйлдвэр болон үйлдвэрлэгч ААН-д тушаасан.Луус суманд хуванцар пресслэгч машинтай болж иргэнд ашиглуулахаар гэрээ байгуулсан. Дэлгэрхангай сумын дахивар цуглуулж буй иргэнд байгаль хамгаалах сангаас 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.Аймгийн төвийн орон сууцны хорооллуудад 9ширхэг ангилан ялгах хогийн сав буюу дахивар цуглуулах цэг байршуулсан. | 90 | | |
| | 183 | | XXV.3.2.11.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоох, шинэчлэн боловсруулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нийтийн болон амины орон сууцны бүсчлэлийг тогтоож, 2023 онд Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 5.4 га газарт "Түмний хороолол"-ын 720 айлын орон сууц, 9-р багт 8 га газарт 115 айлын "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тус тус хийлгүүлэн аймгийн ИТХ-аар батлуулсан. | 100 | | |
| | 184 | | XVII.2.4.Орон нутагт мах худалдан авах явуулын цэг | Сайнцагаан суманд үйл ажиллагаа явуулдаг махны худалдаа эрхлэгчид 12 малчдын бэлтгэсэн | 100 | Өвөлжилтийн нөхцөл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллуулах боломжийг судалж, холбогдох шийдвэрийг гарган арилжааны банкнуудтай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | махыг  малчны хотноос буюу газар дээр очиж  явуулын худалдан авалт хийж  зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлж өөрийн аймгийн болон Нийслэл, Өмнөговь аймгийн хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байна. Мөн махны худалдаа эрхлэгч Баян Зэгстийн Говь ХХК малчдын хотноос 2000 бог малыг малчдын гар дээрээс авч Налайх дүүргийн Траст трейд махны үйлдвэрт худалдаалсан. | | байдал хүндэрсэнтэй холбоотой үйл ажиллагаа тул хасуулах саналтай байна | |
| 109 | 185 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл 2023-12-27 Дугаар 2023_52 | XL.3.3. Батлагдсан төсөвт эх үүсвэрийнхээ хүрээнд мал, махны борлуулалт, худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | Орон нутгийн төсөвт 500 сая төгрөг батлагдсан. | | | |
| | 186 | | XXXX.11.4. Монгол Улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглаврыг гадаадад сурталчлах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин нарт, цаглаварт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ болон Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.” | Олон улсын арга хэмжээний цаглаварт тус аймагт 2024 онд зохион байгуулагдах 3 эвент үйл ажиллагаа “Тэмээний өв соёлын баяр”, “Сэтгэшгүй оддын чуулган”, “Адуучны өв соёлын баяр” жагсаалтыг хүргүүлж цаглаварт оруулсан. Соёлын Яам болон Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоо хамтран эвент үйл ажиллагааны календарийг хэвлүүлж, тур оператор компаниудаар дамжуулан голлох зах зээлийн орнууд Хятад, Солонгос, Япон, Хонконг, Герман зэрэг орнуудад сурталчлагдаж байна. Цаглаварт орсон Сэтгэшгүй оддын чуулган, Торгоны зам авторалли эвент арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 110 | 187 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2024-01-31 Дугаар 2024_5 | 12.9.2. Орон нутагт мал, мах худалдаалах зориулалтын цэг байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Өвөлжилт хүндэрч малчид малаа олноор төхөөрч мах бэлтгэсэнтэй холбооттойгоор ХХААХҮЯамнаас Нийслэлд махны үзэсгэлэн худалдааг зохион байгуулж Орон нутгаас малчид бэлтгэсэн махаа хуваарийн дагуу Лавай худалдааны төв, Цэнгэлдэх хүрээлэн зэрэг газруудад 12 сарын сумын давхардсан тоогоор 45 малчин өрх нийт 768 тн махыг худалдан борлуулж хүн амын хэрэгцээнд нийлүүлж явуулын худалдааг хийсэн. Аймгийн төвд“Мянгат алтан судар” ХХК, “Эрмэг шонхор” ХХК, “Номгон рашаан” ХХК-д нь өөрсдийн нэрийн дэлгүүр болон агуулахаас суурин газрын хүн амын хэрэгцээнд жижиглэнгээр болон гулууз хэлбэрээр худалдаалсан. | 100 | Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотой үйл ажиллагаа тул хасуулах саналтай байна | |
| 111 | 188 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэл 2024-02-28 Дугаар 2024_8 | 22.6.2. Зудын улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг өргөн хүрээтэй, шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Малын сэг зэмийг цуглуулж, булшилж устгах ажлыг зохион байгуулж тэмээ 341, адуу 33404, үхэр 8743, хонь 126313, ямаа 112318 нийт 281119 сэг зэмийг устгаж 97.9 хувьтай хийгдсэн. Малын сэг зэм устгах ажилд сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 45 малын эмч, мэргэжилтэн, Сумдын ЗДТГ-аас 171, орон нутгаас 374, цагийн ажилтан 205 нийт 795 хүн ажилласан. Суудлын автомашин 40, ковш 27, экскаватор 17, Ачааны авто машин 216, нийт 300 техник хэрэгсэл ажилласан байна. Түлш шатахуун 51484 литр дизель түлш, 10474 литр АИ-92 нийт 61958 литр шатахуун зарцуулаад байна. Техник хэрэгслийн түрээс, цагийн ажилтны хөлс, түлш шатахууны зардал нийт 405451160 төгрөгийн санхүүжилтийг сумдын өөрийн нөөц хөрөнгө болон зээлээр зарцуулаад байна. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 105600000 төгрөг сумдад хуваарилсан." | 100 | ОН 10.560 | |
| | 189 | | 22.10.3. Орон нутгийн хэмжээнд бэлтгэсэн махны | Өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 13 аж ахуйн нэгж, 1 иргэний бэлтгэсэн үхрийн мах 23 тн, хонины мах | 100 | нөөцийн мах борлуулагдаж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чанар, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх, стандартын шаардлага хангасан махыг төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | 524.2 тн, ямааны мах 450.7 тн нийт 1003.9 махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж,1146 мал эмнэлгийн гэрчилгээг баталгаажуулсан. | | дууссан тул хасах саналтай | |
| 112 | 190 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12 | 14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав.” (Үндэсний | Ус цаг уурын байгууллагын мэргэжилтнүүдийн баг, Байгал орчин, аялал жуулчлалын газрын захиалгаар ТББ-аар гүйцэтгүүлсэн болон аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас хийсэн нийт 13 судалгааны ажлыг тус мэдээллийн санд байршуулж 5657 иргэн нээж үзсэн нь өмнөх сараас 12,5 хувь, 2969 иргэн судалгааны ажлуудыг татан авсан нь өмнөх сараас 15,1 хувиар тус тус хандалтын тоо өссөн үзүүлэлттэй байна. Одоогоор судалгааны ажлуудад санал сэтгэгдэл үлдээсэн мэдээлэл байхгүй байна. | 90 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар ) | | | | |
| 113 | 191 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13 | 22.6.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар) | 2024 онд шинээр хэрэгжүүлэх нийт 20.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "240 суудалтай соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /Дундговь, Цагаандэлгэр/", "Соёл, урлагийн цогцолборын барилга /Дундговь, Өндөршил сум/", "Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Дундговь, Өлзийт сум/", "Нэгдсэн эмнэлгийн мэс заслын вакум өрөөний тохижилт, тоног төхөөрөмж /Дундговь, Сайнцагаан сум/", "Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл Говь-Сүмбэр, Дундговь/", "Ахмадын өргөөний барилга /Дундговь, Гурвансайхан сум/", "Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Дундговь, Сайнцагаан сум/", "Төв халхын дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/", "Ахмадын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Дундговь/" 9 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн. Үүнээс хагас жилийн байдлаар нийт 9.1 тэрбум төгрөгийн "240 суудалтай соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажил /Дундговь, Цагаандэлгэр/", "Соёл, урлагийн цогцолборын барилга /Дундговь, Өндөршил сум/", "Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Говь-Сүмбэр, Дундговь/", "Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Дундговь, Сайнцагаан сум/", "Ахмадын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Дундговь/" 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар ил тод нээлттэй зохион байгуулаад байна. | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | 192 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл 2024-04-10 Дугаар 2024_14 | 14.17.1.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг Газрын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(.Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн талаар ) | 2023 оны газрын нэгдмэл сангийн газар шилжилт хөдөлгөөнөөр Хөдөө аж ахуйн бэлчээрийн газраас 148752,4 га талбай хасагдаж (Хот тосгон бусад суурины газрын ангиллын газарт) 1708,48 га, (Зам шугам сүлжээний ангиллын газарт) 147041,92 га, (Ойн сан бүхий газарт) 2 га талбай шилжсэн байна. Хот тосгон бусад суурин газрын нийтийн эдэлбэр газраас Зам шугам сүлжээний газрын ангиллын 6,87 га газар, (Ойн сан бүхий газарт) 3 га газар, (Үйлдвэрийн газарт) 0,16 га газар, Хот тосгон, бусад суурины газрын ангиллын (Барилга байгууламжийн дэвсгэр газарт) 103,73 га газар, (Хөдөө аж ахуйн усалгаатай тариалангийн газарт) 2,5 га газар тус тус нэмэгдэж газрын шилжилт хийгдсэн байна. Усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй. | 100 | | |
| | 193 | | 14.17.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав; | Аймгийн хэмжээнд 100га талбайд 80хонь таарч байгаа стандарт нормоос хэтэрч гарсан дүнтэй байна. Баянжаргалан, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Дэрэн, Өндөршил сумдын малчдын зөвлөгөөнд 710 малчинд тэжээлийн ургамал тариалах, бэлчээр сэлгэж зохистой ашиглах, сайжруулах, бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх талаар мэдээлэл сургалт зохион байгуулсан. | 100 | | |
| 115 | 194 | Монгол Улсын Засгийн газрын 2024 | 20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын | Дундговь аймгийн 22 төрийн байгууллага, 15 сум, 2 төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15 | тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;(Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар ) | өөрийн сайт болон нээлттэй мэдээллийн нэгдсэн системд эрх үүсгэгдэн мэдээллээ байршуулан, тухай бүр шинэчлэн 1,2 улирлын үнэлгээ хийгдэж байна. | | | |
| 116 | 195 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16 | 26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | Аймгийн хэмжээнд шатахуун түгээх станц, хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгогдоогүй болно. аймгийн хэмжээнд шатахуун түгээх станц, хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгогдоогүй болно. | 100 | | |
| | 196 | | 26.3.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцад орчны дүрс | Тус аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 12 шатахуун түгээх станцыг Монгол Улсад мөрдөгдөж буй MNS6423:2019 стандартын шаардлага хангасан теле хяналтын камерын системийг байршуулан энэ онд орон нутгийн хөгжлийн сангийн 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх камержуулалтын ажилтай хамтатган орон | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бичлэгийн техник, хэрэгслийг байршуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр болон бүх шатны Засаг дарга нарт; | нутгийн цагдаагийн байгууллагын хяналтын сүлжээнд холбох ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. | | | |
| 117 | 197 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1 | 28.3.1. “Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны А/145 дугаар захирамжаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороог төрийн байгууллагын төлөөлөл 5, Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл 5, Ажил олгогч эздийн холбоо төлөөлөл 5 нийт 15 гишүүнтэйгээр байгуулсан. Тус зөвлөлөөс хамтын хэлэлцээрт тусгах саналд өөрчлөлт оруулах болсон тул хэлэлцээр хийгдээгүй байна. | 80 | | |
| 118 | 198 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1 | 19.3.2.Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг | Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтыг зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027 | **** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав. | | | | |
| 119 | 199 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1 | 22.5.2. Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | Тус аймгийн хэмжээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль төлөвлөсөн орон сууцны хотхон, хороолол баригдаагүй болно. | 100 | | |
| 120 | 200 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1 | 19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх | Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдээлэл сургалтыг Эрдэнэдалай, Сайнцагаан, Дэлгэрцогт, Луус, Дэрэн, Цагаандэлгэр, Сайхан овоо, Баянжаргалан сумдын “Малчдын нэг өдөр” зөвлөгөөнөөр дамжуулан 1216 малчинд мэдээлэл хүргэж ажилласан. Мөн цахим орчинд live нэвтрүүлэг хэлбэрээр иргэд олон нийтэд тус арга хэмжээний талаар мэдээлэл хийж 6100 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн талаар ) | хүний хандалт авсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвөөр 100 малчин өрхийг малжуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 15 сумын 58 төсөлд үнэлгээ хийж 57 малчин өрх тус хөтөлбөрт хамрагдахаар батламжаа гардан аваад байна. | | | |
| 121 | 201 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22 | 37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон | 4 сарын 26-ны өдөр UG Arena-д болсон "Шинэ хоршоо хөдөлгөөний" нэгдсэн арга хэмжээний нээлтэд 139 малчид, хоршоологчдын төлөөлөл, 5 сарын 4-ны өдөр Өмнөговь аймагт болсон Говийн бүсийн нээлтэд 90 малчид, хоршоологчдын төлөөлөл оролцсон. 15 сумын 9 суманд ЗГХЭГазраас бэлтгэн явуулсан сургагч багш нар ажилласан. 10 суманд 18 сургагч багш ажиллаж байна. Нийт 67 удаагийн сургалтыг зохион байгуулж 4021 иргэнд мэдээлэл хүргэсэн. Хоршооны мэдээлэл авсан 4366 иргэн буюу 2183 өрх байна. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 63 хоршоо шинээр байгуулагдсан. Дундговь аймаг нийт 15 сумтай бөгөөд одоогийн байдлаар 9 сум нь дэд ажлын хэсгийг байгуулаад байна. 15 сумын 13 сум малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж тухай суманд ажиллаж буй сургагч багш нар болон | 90 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт | сумдын хоршоо хариуцсан мэргэжилтэн нар, Өндөршил, Дэрэн суманд Аймгийн ЖДҮ, Хоршоо хариуцсан мэргэжилтэн Шинэ хоршоо хөдөлгөөний ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |
| 122 | 202 | Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5 | 5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1. Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2. Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо ГҮТББ-тай хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Эко жорлон” арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 15 сумын удирдлагууд, төрийн албан хаагч, иргэд 120 иргэнд нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, стандарт, эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийн талаар сургалт зохион байгуулсан. “Эко жорлон” үзэсгэлэнгээр хуурай технологийн 8 төрөл, электрон ухаалаг нэг, ус хэмнэлтийн хуйлруулагч хошуу бүхий 2 төрөл, соруулдаг нүхэн жорлонгийн 1 төрөл нийт 13 төрлийн жорлонгийн танилцуулга, үзэсгэлэнг 200 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 2024 онд шинээр стандартын шаардлага хангасан 5 ариун цэврийн байгууламж нэмэгдэж аймгийн хэмжээнд эко ариун цэврийн байгууламжийн тоо 156 болж нэмэгдсэн. Банкны ногоон зээлээр бага оврын цэвэрлэх байгууламж авч ашиглаж буй иргэний ариун цэврийн байгууламжтыг сурталчлах мэдээлэл бэлтгэж байгууллагын пэйж хуудсаар түгээн 1400 хүнд хүргэсэн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө, шийдлийг танилцуулах. | | | | |